



СОЁМБО



БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2020.12.28 №51, 52 (10728, 10729)

Үнэ 500 төгрөг

Дугаар эрхэлсэн ахмад М.МӨНХЗОРИГ



МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улсын Батлан хамгаалах салбарын нийт бие бүрэлдэхүүн, генерал, офицер, ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат албаны түрүүч, байлдагч, ажилтан албан хаагчид аа!

Дэлхийн халуун цэгүүдэд энх тайван, амар амгаланг сахиулах хүндтэй бөгөөд хариуцлагатай үүргээ нэр төртэйгээр гүйцэтгэж яваа цэнхэр дуулгат Энхийг сахиулагчид аа!

Улс орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолыг баталгаажуулах, өнөөгийн амар тайван амьдралыг цогцлоход залуу нас, оюун ухаан, хөдөлмөр бүтээлээ зориулсан ахмад дайчид аа!

Та бүхэндээ Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний болон Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгуулагдсаны 109 жилийн ойн баяр, ирж буй шинэ оны мэндийг Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн нэрийн өмнөөс болон хувисаа өргөн дэвшүүлье!

Монголын ард түмэн 1911 оны цагагчин гахай жилийн өвлийн дунд сарын шинийн есөн буюу аргын тооллын 1911 оны 12 дугаар сарын 29-ний өдөр 200 гаруй жил үргэлжилсэн Манж Чин гүрний ноёрхлыг эцэс болгон, үндэсний тусгаар тогтнолоо зарлаж, VIII Богдыг Монгол Улсын шашин, төрийг хослон баригч, хэмжээгүй эрхт хаанд өргөмжилсөн ба түүнд төрийн тамга, далбаа, өргөмжлөл, хүндэтгэлийг өргөн, улмаар таван яам бүхий Засгийн газрыг анхлан байгуулах түүхэн шийдвэр гаргаж, тусгаар тогтносон Богд хаант Монгол Улсыг байгуулсан түүхтэй. Дээрх Богд хаант Монгол Улсын Засгийн газрын анхны таван яамны нэг нь "Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яам" буюу өнөөгийн "Батлан хамгаалах яам" байсан юм.

Түүхийн хугацаанд Батлан хамгаалах яам нь 1911 оноос "Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яам", 1921 оноос "Ардын засгийн Цэргийн яам", 1922 оноос "Ардын эрхт Монгол Улсын Цэргийн явдлын яам", 1924 оноос "БНМАУ-ын Цэргийн явдлын яам", 1949 оноос "Улсыг Батлан хамгаалах яам", 1955 оноос "Цэрэг ба Нийгмийг аюулаас хамгаалах хэргийг эрхлэх яам", 1959 оноос "БНМАУ-ын Ардын цэргийг эрхлэх яам", 1968 оноос "БНМАУ-ын Батлан хамгаалах яам", 1992 оноос "Монгол Улсын Батлан хамгаалах яам" хэмээн нэрлэгдэж, тухай бүрдээ ажил үүргийн чиглэл, цар хүрээ нь өөрчлөгдөж ирсэн түүхтэй.

Улиран одож буй 2020 он Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний хэмжээнд ололт, амжилт дүүрэн, хийж хэрэгжүүлсэн олон томоохон ажлуудын ард гарсан он байлаа. Тухайлбал, Батлан хамгаалахын хууль тогтоомжийн хэрэгжилтийг бодит ажил хэрэг болгох, зарим хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах замаар эрх зүйн орчныг төгөлдөржүүлэх, Зэвсэгт хүчний бүтцэд төрлийн цэргүүдийг шинээр байгуулах, улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд Зэвсэгт хүчний оролцоог өргөжүүлэх, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт батлан хамгаалах зорилт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон оруулах, алба хаагчдынхаа нийгмийн хамгааллыг дээшлүүлэхэд бодит шийдвэр гаргасан чухал жил байлаа.

Айлчлан ирж буй 2021 он Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний хэмжээнд түүхэн жил байх болно. Ирэх онд Батлан хамгаалах яамны 110, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн түүхт ойнүүд тохих бөгөөд энэхүү ойд бэлтгэх, тэмдэглэн өнгөрүүлэх тухай шийдвэр гаргаад байна.

Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг цэргийн шинэчлэлийн бодлоготой уялдуулан хангах, зэвсэглэл, цэргийн техникийн шинэчлэлийг эрчимжүүлэх, бие бүрэлдэхүүний алба хаах нөхцөл, ажиллаж, амьдрах ая тухтай орчныг бүрдүүлэх, нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр олон бодит ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байгааг тэмдэглэхэд таатай байна.

Ингээд Та бүхэндээ Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний болон Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгуулагдсаны 109 жилийн ойн баярын мэндийг дахин хүргэж, ирж буй шинэ оноо төвшин дүүрэн угтаж, амжилт бүтээл арвин, санаж, сэдсэн үйлс бүхэн нь сэтгэлчлэн бүтэхийн өлзийтэй ерөөлийг дэвшүүлье!

Та бүхнийг маань Мөнх хөх тэнгэр, Монгол цэргийн сүр хүч, сүлд хийморь мөнхөд ивээх болтугай.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Г.САЙХАНБАЯР



Монгол Улсын Зэвсэгт хүчний генерал, офицер, ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат албаны дайчид, туурга тусгаар улс гүрнийхээ ариун голомтыг сахин хамгаалж, төр улсынхаа аюулгүй байдлыг батлан хамгаалах нэр хүндтэй, хариуцлагатай үүргээ биелүүлж буй төрийн цэргийн байгууллын нийт цэргийн алба хаагчид, хилийн чанадад үүрэг гүйцэтгэж байгаа энхийг сахиулагчид, бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмад дайчид, ажилтан, албан хаагчид Та бүхэнд болон Таны гэр бүлд ирж буй шинэ оны баярын мэндийг дэвшүүлье!

Та бид хамтдаа өвөг дээдсийнхээ баатарлаг үйл хэрэг, дайчин замналыг үргэлжлүүлэн Монгол цэргийн шилдэг уламжлалаа бататган баяжуулсан амжилт бүтээлтэй нэгэн оныг үдэж, шинэ онтойгоо учран золгож байна.

Дэлхий дахиныг айдаст автуулсан цар тахлын аюул үүссэн нөхцөл байдалд Зэвсэгт хүчин дэвшүүлсэн зорилтоо бүрэн хангаж, тайван цагт хуулиар хүлээсэн чиг үүргээ амжилттай хэрэгжүүлж байна.

Зэвсэгт хүчний эрх зүйн орчныг боловсронгуй болгох, Зэвсэгт хүчний байгуулалтыг төгөлдөржүүлэх ажлын хүрээнд хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүдийн хэрэгжилтийг хангах, шинэ төрлийн цэргийн командлалуудыг байгуулах ажлыг эхлүүлэх, бие бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, улс орны их бүтээн байгуулалтад оролцох, бие бүрэлдэхүүний нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар дэвшил гарсан нэгэн он түүхийн хуудаснаа үлдэж байна.

Тухайлбал, 2020 онд Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн шинэлэг санаа, бүтээлээр зэвсэглэл, техникийн шинэчлэлийн суурийг бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж, цэргийн сургалт, бэлтгэлийн чанарыг дээшлүүлэхэд онцгой анхаарч сургалтын хөтөлбөр, агуулгыг шинэчлэх ажлыг эхлүүлэхэд байна.

Түүнчлэн Зэвсэгт хүчин Төр засгаас даалгасан үүргийн дагуу эх орныхоо бүтээн байгуулалтын тэргүүн эгнээнд манлайлан оролцож, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.16 км төмөр замын доод бүтцийн ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэснээс гадна төмөр замын гүүр, хоолой, инженерийн байгууламж, дэд бүтцийн үйлдвэрлэл, угсралтын ажлыг гүйцэтгэх бүрэн боломжтой гэдгээ батлан харуулсан зэрэг бүтээлч он жил болсныг ЗХЖШ-ын даргын хувьд тэмдэглэн хэлэхэд таатай байна. Ололт амжилт, сургамж туршлагаар дүүрэн 2020 оныхоо ажлын үр дүнд дүгнэлт хийж, цаашид улам бэхжүүлнэ гэдэгт ч итгэл дүүрэн байна.

Ирэх онд бид өнөө цагийн Зэвсэгт хүчнийхээ яруу алдарт 100 жилийн түүхэн ойг угтана. Цаг үеийн онцгой шаардлага, дэглэмтэй бүхий л үйл ажиллагаагаа нягт уялдуулан Батлан хамгаалах бодлого, зорилтыг хэрэгжүүлж, Зэвсэгт хүчний байгуулалтыг төгөлдөржүүлэх, Зэвсэгт хүчний тухай хуулийн хэрэгжилтийг хангах, шинээр байгуулагдсан командлалуудын бие даасан ажиллагааг төлөвшүүлэх, Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх бэлэн байдал, үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх, бүтээн байгуулалтын үйл ажиллагааг үргэлжлүүлэх зэрэг томоохон үүрэг, зорилтууд тулгамдаж байна. Эдгээр үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх нь Зэвсэгт хүчнийхээ түүхт ойд барих бидний бэлэг байх болно.

Энэхүү зорилго, зорилтуудыг ажил хэрэг болгоход Зэвсэгт хүчний алба хаагч бүрийн идэвхтэй оролцоо, дэмжлэг, бүтээлч сэтгэлгээ, ажил хэрэгч чанар, хариуцлагатай, ёс зүйтэй үйл ажиллагаа юу юунаас илүү эрхэм чухал гэдгийг цохон тэмдэглэе.

Ирээдүйд тэмүүлсэн өөдрөг үзэл, өрнүүн амжилт өөд урин дуудаж буй шинэ оноо халуун ам бул, хамт олон, найз нөхдөөрөө сайхан угтаж, ирж буй 2021 ондоо эрүүл энх, ажил үйлс нь өөдрөг, аз хийморь, цог золбоотой явахын ерөөлийг өргөе!
МОНГОЛ ЦЭРГИЙН СҮР ХҮЧ, ЦОГ ХИЙМОРЬ МАНДАН БАДРАХ БОЛТУГАЙ.

МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Д.ГАНЗОРИГ

ШИНЭ ОНЫ БАЯРЫН МЭНД ДЭВШҮҮЛЬЕ!



БЕЛАРУСИЙН ЭЛЧИН САЙДЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА



Өнгөрсөн долоо хоногийн Мягмар гарагт Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Ганзориг Бүгд Найрамдах Беларусь Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Станислав Чепурнойг хүлээн авч уулзлаа. Тус уулзалтад Зэвсэгт хүчний Жанжин штабын Цэргийн хамтын

ажиллагааны хэлтсийн дарга, хурандаа Н.Нямжаргал, Батлан хамгаалах яамны Гадаад хамтын ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Г.Одбаяр, Бүгд Найрамдах Беларусь Улсын Элчин сайдын яамны зөвлөх В.Г.Мрочек нар оролцож тодорхой асуудлаар санал солилцлоо.

“ЦЭРГИЙН НААДАМ-2021” ...

Олон улсын “Цэргийн наадам-2021”-ын анхан шатны төлөвлөлтийн цахим хурал энэ сарын 17-ны өдрийн 16.05-19.00 цагийн хооронд зохион байгуулагдлаа. Тус цахим хуралд ОХУ, БНХАУ, Энэтхэг, Беларусь, Казахстан, Узбекистан, Иран, Шри-Ланк, Армени, Вьетнам улсын Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний төлөөлөгчид оролцсон бол Монгол Улсын талаас Зэвсэгт хүчний Жанжин штабын орлогч дарга, хошууч генерал Ж.Бадамбазар, Ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын генерал С.Дашзэвэг, Материал техникийн газрын даргын орлогч, техникийн хэлтсийн дарга, хурандаа Ц.Төрмөнх, Сургалтын хэлтсийн Биеийн тамир, спортын тасгийн дарга, хурандаа Д.Цог-Эрдэнэ, Батлан хамгаалах яамны Гадаад хамтын ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Г.Одбаяр нар оролцлоо. Цахим хурлаар олон улсын цэргийн наадмын хүрээнд 2021 онд зохион байгуулах тэмцээн, уралдааны



талаарх мэдээллийг танилцуулж, харилцан санал солилцон зарим асуудлыг шийдвэрлэлээ.

Үүний дараа олон улсын “Цэргийн наадам-2021”-д оролцогч улсууд өөрийн улсад зохиогдох тэмцээн, уралдааны талаар танилцуулга хийж зарим анхаарал татсан асуудлаар санал солилцсон бөгөөд Зэвсэгт хүчний Жанжин штабын

орлогч дарга, хошууч генерал Ж.Бадамбазар “Аравт-2021” морин цэргийн уралдаан, “Авторалли” тэмцээний эхний шатыг Монгол Улсын нутаг дэвсгэрт зохион байгуулах талаар танилцуулга хийж цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой комиссын шийдвэрийг хүлээж буй талаар уламжилсан юм.

ЖИЛИЙН АЖЛАА ДҮГНЭН ХЭЛЭЛЦЭВ

Зэвсэгт хүчний Жанжин штабын 2020 оны үйл ажиллагааны тайлангийн хурал өнгөрсөн долоо хоногт болж өндөрлөлөө. Тайлангийн хуралд Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Ганзориг болон Зэвсэгт хүчний Жанжин штабын газар, хэлтсийн удирдлагууд оролцов. Хурлын эхэнд Зэвсэгт хүчний Жанжин штабын нэгдүгээр орлогч дарга, хурандаа Ц.Жавхланбаатар энэ онд хийж хэрэгжүүлсэн болон бүтээлч ажлуудын талаарх мэдээллийг нэгтгэн танилцуулсан бол залуулан Зэвсэгт хүчний Жанжин штабын Хяналт, шинжилгээ, үнэлгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, хурандаа Д.Ариунболд тус тайланд хөндлөнгийн үнэлгээ хийснээ нэгтгэж Зэвсэгт хүчний Жанжин штаб 2020 онд дэвшүүлсэн зорилго, зорилго бүрэн биелүүлсэн хэмээн дүгнэлээ. Энэ үеэр Зэвсэгт хүчний Жанжин штаб нь хууль, эрх зүйн шинэчлэлийг улам төгөлдөржүүлэх, алба хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр тодорхой түвшинд ахиц гаргасан зэргээр амжилттай ажилласныг онцлолоо.

Энэ үеэр Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Зэвсэгт хүчний Жанжин штабын газар, хэлтсийн удирдлагуудад хандан Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний хууль, эрх зүйн орчныг улам төгөлдөржүүлэхийн төлөө гар нийлэн ажиллаж, ажилтан алба хаагч бүр хуулиа дээдэлж, сахилга харууцлагаа дээшлүүлэн ирэх жилдээ амжилт бүтээлээр дүүрэн байхын ерөөлийг дэвшүүлэв.

Хурлын төгсгөлд Зэвсэгт хүчний алба хаагчдаас энэ онд идэвх, зүтгэл гаргаж ажилласан шилдэг ажилтан, алба хаагчдаа шалгарууллаа. Тодруулбал, “Зэвсэгт хүчний оны Тэргүүний цэргийн гэрээт алба хаагч”-аар Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн Инженер сапёрын салааны тасгийн захирагч, ахлах түрүүч Л.Алтанбаяр, “Зэвсэгт хүчний оны Тэргүүний ажилтан албан хаагч”-аар Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн Хяналт, үйлчилгээний

ротын ээлжийн тогооч Х.Должинсүрэн, “Зэвсэгт хүчний оны Тэргүүний ахлагч”-аар Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн Тусгай тээврийн ротын жолооч, ахлах ахлагч А.Уламбаатар, “Зэвсэгт хүчний оны Тэргүүний офицер”-оор Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Агаарын довтолгооноос хамгаалах хэлтсийн электроникийн инженер, ахлах дэслэгч Т.Тайшир, “Зэвсэгт хүчний оны Тэргүүний салбар”-аар Зэвсэгт хүчний 148 дүгээр салбар, “Зэвсэгт хүчний оны Тэргүүний анги”-аар Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл манлайлав.

Харин Зэвсэгт хүчний Жанжин штабаас



“Оны Тэргүүний ажилтан албан хаагч”-аар БХЯ, ЗХЖШ-ын Үйлчилгээ, аж ахуйн хэлтсийн жолооч Б.Насанжаргал, “ЗХЖШ-ын оны Тэргүүний ахлагч, туслах мэргэжилтэн”-ээр Захиргаа удирдлагын хэлтсийн нууц бичиг хэргийн эрхлэгч, сургагч ахлагч Д.Дашиймаа, “Оны Тэргүүний мэргэжилтэн”-ээр Санхүүгийн хэлтсийн нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн, ахмад Ч.Ганчулуун, “Оны Тэргүүний ахлах мэргэжилтэн”-ээр Захиргаа удирдлагын хэлтсийн хуулийн зөвлөх, ахлах мэргэжилтэн, ахмад А.Эрдэнэмөнх, “Оны Тэргүүний удирдах албан тушаалтан”-гаар Ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын генерал С.Дашзэвэг, “Оны Тэргүүний зохион байгуулалтын бүтцийн нэгж”-ээр Бодлого, стратегийн төлөвлөлтийн газар тус тус шалгарчээ.

ЦЭРЭГЖЛИЙН СПОРТЫН АВАРГУУД ТОДОРЛОО

Зэвсэгт хүчний 2019-2020 оны сургуулийн жилийн “Цэргийн сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөө”-ний дагуу зохион байгуулагдсан “Цэргийн биеийн тамирын сургалт бэлтгэл”, “Спорт-нийтийн биеийн тамирын тэмцээн”-ний шилдгүүд өнгөрсөн долоо хоногт шалгарлаа. Тодруулбал, тус тэмцээнийг цэрэгжлийн спортын найм, нийтийн биеийн тамирын тав, нийт 13 төрлөөр зохион байгуулсан бөгөөд Зэвсэгт хүчний 084, 350, 330, 150, 311 дүгээр ангиуд эхний таван байрыг эзэллээ. Тэмцээний ялагчдын шагналыг өнгөрсөн долоо хоногт Зэвсэгт хүчний Жанжин штабын орлогч дарга, хошууч генерал Ж.Бадамбазар, Зэвсэгт хүчний Жанжин штабын Сургалтын хэлтсийн Биеийн тамир, спортын тасгийн дарга, хурандаа Д.Цог-Эрдэнэ нар ангийн захирагч нарт нь гардуулан өглөө.

Энэ үеэр Зэвсэгт хүчний Жанжин штабын Сургалтын хэлтсийн Биеийн тамир, спортын тасгийн дарга, хурандаа Д.Цог-Эрдэнэ “Бид

энэ жилийн цэрэгжлийн спортын уралдаан тэмцээнүүдийн дүнг гаргаж Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалаар баталгаажуулсан ба эхний таван байрт шалгарсан ангиудад шагналыг нь гардууллаа. Жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 4900 гаруй цэргийн алба хаагч спорт-нийтийн биеийн тамирын тэмцээнүүдэд оролцсон байна. Энэ нь цар тахлаас үүдэн цаг үеийн хүндхэн нөхцөл байдал үүссэн ч нэгтгэл, анги, салбарууд бие бүрэлдэхүүнээ идэвхтэйгээр бэлтгэж, цэргийн сургалт бэлтгэл хэвийн явагдаж байгааг харуулсан. Цэрэгжлийн спортын тэмцээн, уралдаан бол нэгтгэл, анги, салбарынхаа нэр төрийг гаргах, сурсан мэдсэнээ тодоор харуулах чухал ач холбогдолтой. Үүнийгээ дагаад ч маш өргөн хүрээнд зохион байгуулагддаг. Энэ жилийн хувьд цэрэгжлийн спортын төрлүүдээс гадна сагс, гар бөмбөг, хөл бөмбөг зэрэг нийтийн биеийн тамирын төрлүүдээр зохион явуулсан. Дээрээс нь, бид уламжлалт

тэмцээнүүддээ рагбигийн спортын төрлийг нэмсэн. Энэ спорт бол хурд, хүч, тэсвэр зэрэг олон шинж чанарыг агуулдаг учир цэргийн алба хаагчид хичээллэхэд нэн тохиромжтой. Нийтийн биеийн тамирын спортын төрлүүдээр тэмцээн, уралдааныг зохион байгуулсан нь бие бүрэлдэхүүний багаар ажиллах чадварыг хөгжүүлдэг онцлогтой. Мөн энэ жилийн тухайд хөдөө, орон нутгаас маш олон багууд ирж оролцсон нь бахархуштай. Жишээ нь, алс хязгаар нутгаас ирж оролцсон Зэвсэгт хүчний 331, 327 дугаар ангийн алба хаагчид өндөр зохион байгуулалттайгаар өрсөлдсөн. Дээрээс нь, Цэргийн төв эмнэлгийн хамт олон маш хүнд нөхцөл байдалд албан үүргээ гүйцэтгэж байгаа хэдий ч цэрэгжлийн спортын уралдаан, тэмцээндээ идэвхтэй оролцож чадсан. Эцэст нь дүгнэхэд, энэ жилийн уралдаан, тэмцээнүүд нь монгол цэрэг дотооддоо болон дэлхийн хэмжээнд өрсөлдөх чадвартай гэдгийг бодитоор харуулж чадсан” гэв.

САНХҮҮЧИД ШИЛДГҮҮДЭЭ ТОДРУУЛЛАА



Зэвсэгт хүчний Жанжин штабын Санхүүгийн хэлтсээс жил бүрийн 12 дугаар сарын эхний долоо хоногт тохиодог “Санхүүчдийн баяр”-аар Зэвсэгт хүчний Жанжин штаб болон Төрийн цэргийн командлалын харьяа нэгтгэл, анги, салбаруудын нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудаас тухайн жилд хамгийн үр бүтээлтэй ажилласан хоёр алба хаагчийг онцлон шилдгээр шалгаруулдаг уламжлалтай.

Энэ жилийн хувьд “Шилдэг нягтлан бодогч”-оор Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 274 дүгээр салбарын ерөнхий нягтлан бодогч С.Рэмжмаа тодорсон бол “Шилдгийн шилдэг нягтлан бодогч”-оор Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газрын Санхүүгийн хэлтсийн дарга, хурандаа Ц.Баяргэрэл шалгарлаа.

"ОТГОНТЭНГЭР" ИХ СУРГУУЛЬТАЙ ХАМТАРЧ АЖИЛЛАНА

“Монгол цэргийн нэгдсэн холбоо” ТББ-ын үйл ажиллагааны нэг үндсэн чиглэл нь “Монгол Улсын иргэдэд эх орон үзэл, үндэсний бахархлыг төлөвшүүлэхэд төр, иргэний нийгмийн байгууллагууд, иргэдтэй хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх” явдал байдаг. Энэ хүрээнд эх оронч үндэсний үзэл, бахархлыг хөгжүүлэн, ард түмнээ соён гэгээрүүлж, Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын оюуны дархлаа, үнэт зүйлсийг хамгаалан бэхжүүлэх чиглэлээр сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, иргэн-цэргийн харилцааг хөгжүүлэх, дэмжих, хугацаат цэргийн алба хаагчдад дээд боловсролын ач холбогдол, мэргэжил сонголтын чиг баримжааг олгох чиглэлээр хамтран ажиллах ерөнхий зорилготойгоор “Отгонтэнгэр” их сургуультай хамтран ажиллах

санамж бичгийг 12 дугаар сарын 14-ний өдөр цахимаар байгууллаа.

Санамж бичгийн хүрээнд хоёр тал 10 гаруй чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцов. Үүний нэг нь “Эрхмийн дээд монгол хүн” сэдэвт эсээ бичлэгийн уралдааныг зохион байгуулна. Энэхүү уралдааныг аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабууд, салбар холбоодтой хамтран ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн сурагчдын дунд хоёр үе шаттайгаар зохион байгуулах юм. Эсээ бичлэгийн уралдааны талаарх мэдээллийг “Монгол цэргийн нэгдсэн холбоо” ТББ-ын пэйж хуудас, “Отгонтэнгэр” их сургуулийн вэб хуудас болон аймаг, дүүрэг дэх салбар холбоод, Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабуудаас авах боломжтой.

ХУУЛИЙН МЭДЛЭГЭЭ ДЭЭШЛҮҮЛЛЭЭ

Монгол Улсын Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалаас хууль тогтоомжийг сурталчлах, алба хаагчдын эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Хуулийг хэн сайн мэдэх вэ” сэдэвт болзолт уралдааныг зохион байгууллаа. Энэхүү уралдаанд Агаарын командлалын харьяа ангиудын байнгын бие бүрэлдэхүүн мэдлэг оюунаа сорин өрсөлдлөө.

Тус уралдааны тэргүүний ангийн төрөлд Зэвсэгт хүчний 303 дугаар анги шалгарсан бол шилдэг офицерын төрөлд тэргүүн байрыг Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн Холбоо, мэдээллийн албаны зангилгааны дарга, ахмад Ц.Одгэрэл, удаах байруудыг тус ангийн Холбоо, мэдээллийн албаны холбооны хэрэгслийн ахлах инженер, хошууч Х.Цолмончимэг, 353 дугаар ангийн Захиргааны удирдлагын албаны хүний нөөцийн офицер, ахлах дэслэгч Г.Оргилболд нар эзэллээ.

Мөн шилдэг ахлагч нарын төрөлд Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 321 дүгээр тусгай ротын ахлах планшотчин, дэд ахлагч Б.Соддэцэг тэргүүн, цахилгаанчин-дизельчин, ахлах ахлагч Т.Одхүү дэд, Төв командын байрын радиотелеграфчин, дэд ахлагч М.Ариунтуяа гуравдугаар байрын эздээр тодорлоо.

ХУРАНДАА ЦОЛ ОЛГОЛОО

Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалаар эрхэлсэн албандаа идэвх зүтгэлтэй, санаачилгатай, үр бүтээлтэй ажиллаж буй Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Батлан хамгаалах бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, дэд хурандаа М.Батхуяг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын ахлах офицер, дэд хурандаа М.Мөнгөтулга нарт хурандаа цол олголоо. Энэ үеэр Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, хурандаа Д.Ганхуяг хэлсэн үгэндээ "Юуны өмнө хурандаа хэмээх энэхүү хүндтэй цолыг хүртэж байгаад баяр хүргэе. Уг цолыг дагаад та бүхний үүрэг, хариуцлага нэмэгдэж байна. Цаашид ажилдаа улам бүр идэвх чармайлт гаргахыг хүсье" гэв.

АГААРЫН ЦЭРГИЙН ШИЛДГҮҮДЭЭР ...

Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалынхан 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө дүгнэж, энэ оны шилдгүүдээ тодрууллаа. Тодруулбал, "Агаарын цэргийн Тэргүүний анги"-аар дэд хурандаа Д.Шатаррагчаа захирагчтай Зэвсэгт хүчний 303 дугаар анги, "Агаарын цэргийн Тэргүүний салбар"-аар ахмад Д.Батмөнх захирагчтай Зэвсэгт хүчний 090 дүгээр тусгай рот, "Агаарын цэргийн Тэргүүний офицер"-оор Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Агаарын довтолгооноос хамгаалах хэлтсийн электроникийн инженер, ахлах дэслэгч Т.Тайшир, "Агаарын цэргийн Тэргүүний ахлагч"-аар Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 321 дүгээр тусгай ротын ахлах планшетчин, дэд ахлагч Б.Содцэцэг, "Агаарын цэргийн Тэргүүний ажилтан албан хаагч"-аар Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн Нисгэгчгүй нисэх хэрэгслийн судалгааны төвийн багаж хэрэгслийн ашиглалтын

инженер Ч.Бурмаа, "Агаарын цэргийн командлалын Тэргүүний бүтцийн нэгж"-ээр хурандаа Э.Батсайхан даргатай Агаарын довтолгооноос хамгаалах хэлтэс, "Агаарын цэргийн командлалын Тэргүүний удирдах ажилтан"-аар Агаарын цэргийн командлалын штабын дарга, бригадын генерал Б.Батбаяр, "Агаарын цэргийн командлалын Тэргүүний ахлах офицер"-оор Улсын нисэхийн хэлтсийн нисэхийн ерөнхий инженер, ахмад Э.Мөнх-Эрдэнэ, "Агаарын цэргийн командлалын Тэргүүний офицер"-оор Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн сэтгэл зүйн хангалтын офицер, хошууч Э.Очбадрах, "Агаарын цэргийн командлалын Тэргүүний ахлагч"-аар Хүний нөөцийн хэлтсийн хүний нөөцийн хэрэг хөтлөгч, сургагч ахлагч Ж.Бумцэцэг, "Агаарын цэргийн командлалын Тэргүүний ажилтан албан хаагч"-аар Захиргааны удирдлагын хэлтсийн бичээч-оператор Д.Должин нар тус тус тодорчээ.

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГТ ХАНДИВ ГАРДУУЛАВ

"Ковид-19" цар тахал дотоодод тархаж буй энэ үед халдварын голомтод цаг наргүй ажиллаж, гамшгаас урьдчилан сэргийлэх, Үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах үйлсэд хичээл зүтгэл гаргаж буй Цэргийн төв эмнэлгийн хамт олонд Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого төлөвлөлтийн газар, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын хамт олноос 4.6 сая төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн нэг удаагийн хамгаалах хэрэгслийг хандивлалаа. Энэ үеэр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа Ц.Анхбаяр "Цар тахлаас үүдэн Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн энэ цаг үед бид Цэргийн төв эмнэлгийн хамт олонд хандив өгөх аяныг эхлүүлсэн. Тус аяны хүрээнд өдөр, шөнийн алинд ч өндийх завгүй үүргээ баатарлагаар гүйцэтгэж байгаа Зэвсэгт хүчний тодотголтой эмнэлгийн хамт олонд шаардлагатай тусламжийг хүргэхийг зорилго" гэсэн бол Цэргийн төв эмнэлгийн штабын дарга, хурандаа Д.Ганболд "Юуны өмнө баярлаж буйгаа илэрхийлье. Өнгөрсөн хугацаанд Цэргийн төв эмнэлэгт 500 орчим өвчтөн хүлээн авч 200 орчмыг нь бүрэн эдгээж чадсан. Энэ хүнд нөхцөлд та бүхэн тусламжийн гараа сунгаж байгаа нь тун нүдээ олсон үйл явдал боллоо" гэв.

Мөн тус эмнэлгийн хамт олонд Монгол Улсаас Япон Улсад цэргийн сургуульд суралцаж төгссөн болон суралцаж буй нийт офицер, сонсогчид, Япон Улсад суугаа Элчин сайдын яамны Батлан хамгаалахын атташе нар нийлэн хандивын аяныг өрнүүлж 1.3 сая төгрөгийн өртөг бүхий 120 ширхэг хамгаалалтын хувцсыг гардуулан өглөө.

Хилийн чанадаас мэдээлж байна

ДАДЛАГА, УР ЧАДВАРАА НЭМЭГДҮҮЛЖЭЭ



Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж буй НҮБ-ын "UN-MISS" энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй Монгол Улсын Зэвсэгт хүчний Х ээлжийн цэргийн баг ажиллагааны газар оронд үндсэн үүргээ гүйцэтгээд хоёр сар орчмын хугацааг өнгөрөөжээ. Энэ хугацаанд цэргийн багийн бие бүрэлдэхүүн тус орны байгаль, цаг уур болон цар тахлын хүндрэлтэй амаргүй нөхцөлд НҮБ-ын мандатаар хүлээсэн үндсэн үүргээ гүйцэтгэхийн зэрэгцээ сургалт дадлагыг тогтмол зохион байгуулан бэлэн байдал, бэлтгэлжилтийн түвшингээ ахиулсаар байна.

Тодруулбал, штабын офицерууд, салбаруудын захирагч нартай "Юнити" секторын аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө, "Х ээлжийн мотобуудлагын батальоны аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө", "Бэлэн байдлыг хангах төлөвлөгөө"-г тодотгох, удирдлага, штабын бэлэн байдлыг хангах, шаардлагатай тооцоо, удирдлагын баримт бичгүүдийг боловсруулах, офицеруудын мэдлэг, дадлагыг нэмэгдүүлэх зорилгоор "Бэлэн байдлын зэргүүдэд шилжих үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ" сэдвийн хүрээнд энэ оны 12 дугаар сарын 12, 13-ны өдөр штабын дадлага сургуулийг, 14-ний өдөр батальоны нийт бие бүрэлдэхүүнийг хамруулан зохион байгууллаа.

Энэ нь штабын хэсэгчилсэн болон нэгдсэн дадлагын төлөвлөгөөний дагуу батальоныг бэлэн байдлын зэргүүдэд шилжүүлж, хариуцлагын бүсэд харуул хамгаалалтын хүчийг нэмэгдүүлэх, штабын офицер, салбарын захирагч нарын харилцан ажиллагаа, удирдлага, зохион байгуулалтыг болзошгүй цагийн байдалд ойртуулан багаар ажиллах чадварыг нэмэгдүүлсэн чухал ач холбогдолтой дадлага, сургууль боллоо.

Ахлах дэслэгч Г.ЦЭРЭННАДМИД

Б.Гантөмөр: АХЛАГЧ НАРЫН БИЕ БЯЛДРЫН БЭЛТГЭЛЖИЛТ, ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭДЛЭГТ АНХААРНА

Зэвсэгт хүчний Жанжин штабын ахлагч, тэргүүн ахлагч Б.ГАНТӨМӨРТЭЙ ярилцлаа.

Зэвсэгт ахлагчийн төгөлдөржүүлэх талаар ямар ажлыг хийж, хэрэгжүүлж байгаа вэ?

-Бид бүхэн энэ чиглэлээр "Ахлагчийн албыг хөгжүүлэх хөтөлбөр-2021"-ийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ нь ахлагчийн албаны ойрын ирээдүйд хэрэгжүүлэх гол ажлуудыг тусгасан удирдлагын гол баримт бичиг юм. Тус хөтөлбөрт тусгагдсанаар ахлагчийн албаны эрх зүйн зохицуулалтыг Зэвсэгт хүчний хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн тогтолцоог шинэчилж, ахлагч нарын боловсролыг дээшлүүлэх, нийгмийн хамгааллын баталгааг нэмэгдүүлэх зорилгыг

шинээр томилогдсон. Мөн тэдний гүйцэтгэх үүргийг "Цэргийн дотоод албаны дүрэм"-д тодорхой тусган үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

Энэ онд цэргийн гэрээт алба хаах нөхцөл боломж илүү сайжирсан. Энэ талаар тодруулбал ...

-Цэргийн гэрээт албаны түрүүч, байлдагч нарыг ахлагчийн албаны бүрэлдэхүүн хэсэг гэж ойлгож болно. Тиймээс тэдний цалингийн зэрэглэлийг ахлагчийн бүрэлдэхүүний зэрэглэлтэй адилтган шинэчлэн тогтоож, Зэвсэгт хүчний байнгын бүрэлдэхүүний адил үүрэг гүйцэтгэдэг болгосноор цэргийн гэрээт албыг хаах нөхцөл боломжийг нэмэгдүүлсэн. Энэ

техникийн нөхцөл болон шаардлагатай зураг, төсөл хийгдэж дууссан. Одоогоор тус хорооллын үйл ажиллагааг эхлүүлэх чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллах талаар судалж байна.

Ирэх жил ямар ажлуудыг төлөвлөсөн бэ?

-Зэвсэгт хүчний 2020-2021 оны сургуулийн жилд "Ахлагчийн албыг хөгжүүлэх хөтөлбөр-2021" баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавин, "Зэвсэгт хүчний ахлагчийн бүрэлдэхүүний бие бялдар бэлтгэлжилт, эрүүл мэндийг дээшлүүлэх жил" болгон зарласантай холбогдуулан төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын хэрэгжилтийг ханган үр дүнг тооцож ажиллана. Үүний гол зорилго нь ахлагчийн



хэрэгжүүлэхээр гурван үндсэн зорилтын 12 үндсэн чиглэлийн хүрээнд хэрэгжилтийг нь хангуулах 65 арга хэмжээг 2016-2018 он, 2019-2021 оныг дуустал хоёр үе шаттайгаар төлөвлөн ажиллаж байна. Тухайлбал, Зэвсэгт хүчний ахлагчийн бүрэлдэхүүний албан тушаалын ангилал, цэргийн цол, цалингийн зэрэглэлд багагүй өөрчлөлт орсон. Үүнд, ахлагчийн албаны тогтолцоонд даргалах албан тушаалын ахлагч нарт тавигдах шаардлага нь ахлагчийн удирдлагын шаталсан сургалтаар тодорхойлогддог бол мэргэжлийн бүрэлдэхүүний үндэс суурь болсон гүйцэтгэх албан тушаалын ахлагч нарын хувьд тухайн тавигдсан шаардлага, шалгууруудыг хангасан нөхцөлд цэргийн цол, цалингийн зэрэглэлээ шатлан нэмэгдүүлэх боломж бүрдсэн. Түүнчлэн нэгтгэл, ангиуд бүтэц, орон тооны хувьд шинэчлэгдэж, зарим даргалах албан тушаалын ахлагч нар

нь цаашлаад цэргийн гэрээт албаны түрүүч, байлдагч нарыг алба хаах хугацаанд нь мэргэжил эзэмшүүлж өөрийн хүсэлтээр ахлагчийн албанд шилжих боломжийг бүрдүүлэх, Зэвсэгт хүчнээр дамжуулан мэргэжил эзэмшсэн иргэнийг бий болгох боломжийг бүрдүүлж байгаагаараа чухал ач холбогдолтой юм.

"Ахлагч хотхон" хорооллыг байгуулах ажил ямар шатанд явж байгаа вэ?

-Алба хаагчдын нийгмийн хамгааллын асуудал нь маш өргөн цар хүрээтэй учир зөвхөн ахлагчид гэхээсээ илүүтэйгээр Зэвсэгт хүчний нийт бүрэлдэхүүний нийгмийн хамгааллын асуудлаар Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын хэмжээнд авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлууд бий. Энэ ажлын хүрээнд хэрэгжүүлж буй ажлын нэг нь "Ахлагч хотхон" хороолол юм. Батлан хамгаалах яамнаас тодорхой төсөв хөрөнгийг нь шийдвэрлэж тухайн хорооллын

бүрэлдэхүүний бие бялдын бэлтгэлжилт, эрүүл мэндийг дээшлүүлэх замаар тэдний үүрэг гүйцэтгэх чадварыг дээшлүүлэх мөн бие бялдын бэлтгэлжилт, эрүүл мэндийн мэдлэгийг дээшлүүлснээр тухайн цэргийн алба хаагч өвчин эмгэг, гэмтэл бэртлээс өөрийгөө урьдчилан сэргийлэх болон сэтгэл зүй, ёс суртахуун дээшлэх, өгөгдсөн үүргийг биелүүлэх чадвар сайжирдаг. Тиймээс ахлагчийн бүрэлдэхүүний бие бялдын бэлтгэлжилт, эрүүл мэндийн мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээний хүрээнд Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалаар батлагдсан төлөвлөгөөний дагуу цэргийн сургалт бэлтгэлийн журам, стандартыг хэрэгжүүлж ажиллах чиглэлээр Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудад хэд хэдэн арга хэмжээг хэрэгжүүлэн үр дүнг тооцон ажиллана.

Дэд ахлагч Т.ИДЭР

Ц.Жавхланбаатар: ЭХ ОРНЫХОО НЭР ХҮНДИЙГ ӨНДӨРТ ӨРГӨЖ ЯВААРАЙ

Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад явагдаж буй Умард Атлантын гэрээний байгууллага /НАТО/-ын тэргүүлсэн "Шийдвэртэй дэмжлэг" ажиллагаанд ХБНГУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтран үүрэг гүйцэтгэх Монгол Улсын XIII ээлжийн цэргийн багийн бие бүрэлдэхүүнийг хүндэтгэн үдэх ёслол 2020 оны 12 дугаар сарын 19-ний өдөр Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн жагсаалын талбайд боллоо.

Энэ үеэр Зэвсэгт хүчний Жанжин штабын нэгдүгээр орлогч дарга, хурандаа Ц.Жавхланбаатар цэргийн багийн бүрэлдэхүүнд хандаж хэлсэн үгэндээ, тэднийг сахилга баттай, гар нийлэмжтэй ажиллаж Монгол Улсын төр, засаг, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг мэргэжлийн өндөр түвшинд биелүүлэхийг захиж, дэлхий дахиныг түгшээж буй цар тахлын үед үүрэг гүйцэтгэж байгаагаа



үргэлж санаж ариутгал х а л д в а р г ү й ж ү ү л э л т и й н

дэглэмийг чанд сахин ажиллах ёстойг онцлолоо.

БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН 2020 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ, БҮТЭЭЛЧ АЖЛУУД

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАН ЗЭВСЭГТ ХҮЧИНД ШИНЭ ТӨРЛИЙН ЦЭРЭГ БАЙГУУЛАГДАЖ, ЗАРИМ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БОЛОВСРОНГУЙ БОЛЛО

УИХ-ын чуулганы 2020 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар Монгол Улсын Зэвсэгт хүчин түүхэн хөгжлийнхөө явцад урьд байгаагүйгээр өргөжин хөгжих эрх зүйн зохицуулалттай болсон. Ингэснээр Зэвсэгт хүчин нь хуурай замын цэрэг, агаарын цэрэг, барилга-инженерийн цэрэг, кибер аюулгүй байдлын цэрэг болон тусгай хүчний цэргээс бүрдэхээр хуульчлагдсан юм.

Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газрын 2020 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар Зэвсэгт хүчинд "Тусгай хүчний цэргийн командлал", "Кибер аюулгүй байдлын цэргийн командлал", "Барилга-инженерийн цэргийн удирдах газар" байгуулах шийдвэрийг гаргаж, Батлан хамгаалахын сайдын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн тушаалаар баталгаажуулснаар шинэ төрлийн цэргийн удирдлагын байгууллагууд бие даан үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндэс бүрдлээ.

УИХ-ын намрын ээлжит чуулганаар Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг хэлэлцүүлэн шийдвэрлүүлээ. Энэхүү хуулиар "Зэвсэгт хүчний хөгжлийн сан"-г Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан тусгай сангийн төрөлд хамааруулж, бүрдүүлэлт, зарцуулалтын онцлогтой холбогдсон харилцааг Зэвсэгт хүчний тухай хуулиар, нийтлэг харилцааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулах эрх зүйн зохицуулалтыг хийлээ. Хуульд нэмэлт орсноор Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэр нэмэгдэж, Зэвсэгт хүчний хөгжилд нааштай үр дүн үзүүлэх ач холбогдолтой юм.

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ, ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТАЛЛАА

"Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг соёрхон батлах тухай хуулийг УИХ-ын чуулганы 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталлаа. Мөн "Цэргийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Киргиз Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг Засгийн газрын түвшинд, Монгол Улс, НАТО-ийн хооронд байгуулсан "Түншлэл, хамтын ажиллагааны хөтөлбөр"-ийн хугацааг 2024 он хүртэл сунгах асуудлыг Батлан хамгаалах яамны түвшинд шийдвэрлээ.

Энэхүү гэрээ, хэлэлцээрүүд батлагдсанаар Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхлыг хангах, гуравдагч хөршийн бодлогыг хэрэгжүүлэх, хоёр орны батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх эрх зүйн үндэс бүрдэх, хамтын ажиллагаа шинэ түвшинд хүрэх, бүс нутгийн хэмжээнд цэргийн итгэлцэл, харилцан ойлголцлыг бэхжүүлэх, тогтвортой байдлыг хангах, Зэвсэгт хүчний чадварыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой болох юм.

"ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР" БАТЛАГДАЖ, БАТЛАН ХАМГААЛАХЫН ИРЭХ ДӨРВӨН ЖИЛИЙН ЗОРИЛТ, ЗОРИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ ТӨДӨРХОЙ БОЛЛО

Монгол Улсын Их Хурлын ээлжит бус чуулганы 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр" хэлэлцэгдэн УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдаад байна.

Тус хөтөлбөрт туссанаар батлан хамгаалах салбар нь "Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн, чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ" гэсэн тэргүүлэх зорилтын хүрээнд 9 дэд зорилт, 48 арга хэмжээг харьяа агентлаг, төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги, байгууллагаараа дамжуулан хэрэгжүүлэх юм.

Түүнчлэн Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт батлан хамгаалах зорилт, арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийг тусгаж, УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлууллаа.

Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт "Барилга, инженерийн тусгай анги байгуулах", "Барилгын хийц үйлдвэрлэх /UBM/ хөдөлгөөнт цогцолборыг ашиглалтад оруулах", "НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд инженерийн рот, тусгай хүчний ротыг бэлтгэж оролцуулах" зэрэг томоохон төслүүдийг тусгасан юм.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 186 ДУГААР АНГИЙГ ТҮШИГЛЭН ДАЙЧИЛГААТАЙ ТАКТИКИЙН ХЭЭРИЙН СУРГУУЛИЙГ АМЖИЛТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЖ ЯВУУЛЛАА

Засгийн газрын шийдвэрийн дагуу Зэвсэгт хүчний 186 дугаар ангийг дайчилгаатай команд штабын болон байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуулийг 2020 оны 8 дугаар сард амжилттай зохион байгуулж явууллаа.

Дайчилгаатай сургуулийг явуулснаар дайчилгаа зарласан үед Орхон аймгийн удирдлагын дайчилгаа удирдах болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн дайчилгааны даалгаврыг биелүүлэх боломжийг тооцон үнэлэлт өгч, томилгоот бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх мэдлэг, дадлага, чадварыг нэмэгдүүлэн дайчилгааны бэлэн байдлыг дээшлүүлсэн.

Түүнчлэн Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн штабын жигдрэлтийг ханган томилгоот бүрэлдэхүүнийг дайчилгааны арга хэмжээг хэрэгжүүлэхэд сурган дадлагажуулж, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнтэй явуулах сургалтын материаллаг баазыг бэхжүүлж, түр болон удаан хугацааны хадгалалтад байгаа авто, хуягт техник, хээрийн тоног төхөөрөмж, табель хэрэгсэлд сэргээн сайжруулах үйлчилгээг хийж бэлэн байдал, арчлан хамгаалалтыг сайжруулсан нь Зэвсэгт хүчний хуулиар хүлээсэн үүрэг гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой сургууль болсон юм.

ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНЫ ЯЛАЛТЫН 75 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЛЭЭ

Засгийн газрын шийдвэрийн дагуу Чөлөөлөх дайны ялалтын 75 жилийн ойг тэмдэглэх үйл ажиллагааг өргөн хүрээнд зохион байгууллаа. Чөлөөлөх дайнд оролцсон ахмад дайчдад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд (2020 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр) Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Х.Баттулга, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Ганзориг, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн үүрэг гүйцэтгэгч Ж.Батбаясгалан нар оролцож, тэдэнд төрийн дээд одон болон Батлан хамгаалах салбарын шагналыг гардууллаа.

Ойн хүрээнд "Дэлхийн хоёрдугаар дайны төгсгөл:



Манжуурын стратегийн давшилтын ажиллагаанд Монгол Улсын оролцоо" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг Улаанбаатар хот дахь Оросын шинжлэх ухаан, соёлын төвд 2020 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр зохион байгуулсан.

Архивын Ерөнхий газар, Монгол цэргийн музей, Батлан хамгаалахын төв архив, Оросын шинжлэх ухаан, соёлын төв хамтран "Тусгаар тогтнолын үнэ цэн" үзэсгэлэнг 2020 оны 9 дүгээр сарын 1-9-ний өдрүүдэд дэлгэж, Чөлөөлөх дайнтай холбоотой архивын ховор баримтууд, эд өлгийн зүйлс, дайчдын хувцас хэрэглэл зэрэг үзмэрүүдийг олны хүртээл болгосон.

АУГАА ИХ ЭХ ОРНЫ ДАЙНЫ ЯЛАЛТЫН 75 ЖИЛИЙН ОЙН ЦЭРГИЙН ЁСЛОЛЫН ЖАГСААЛД ОРОЛЦЛОО

ОХУ-ын нийслэл Москва хотноо 2020 оны 6 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулагдсан Аугаа их Эх орны дайны ялалтын 75 жилийн ойн баярын арга хэмжээнд хүндэт зочноор Монгол Улсын Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Ганзориг, цэргийн ёслолын жагсаалд Монгол Улсын Зэвсэгт хүчний 75 цэргийн алба хаагч оролцлоо.

Коронавирусний цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан ихэнх гадаад арга хэмжээ хойшлогдож, цуцлагдсан ч Монгол Улс, ОХУ хоорондын батлан хамгаалах салбарын түүхэн харилцаа, хамтын ажиллагаа өндөр түвшинд хэвээр байгааг илтгэн харуулах, Аугаа их Эх орны дайнд ялалт байгуулахад Монголын ард түмний оруулсан үнэтэй хувь нэмрийг дэлхий дахинд сурталчлан таниулах чухал ач холбогдолтой арга хэмжээ болов.

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛГИЙНХЭН "КОВИД-19"-ИЙН ЭСРЭГ ...

Цэргийн төв эмнэлэг нь 2020 оны 2 дугаар сараас эхлэн гадаадын улс орнуудаас 70 гаруй удаагийн тусгай үүргийн нислэгээр болон зургаан удаагийн газрын татан авалтаар ирсэн нийт 1500 гаруй иргэнийг хүлээн авч, үүнээс халдварын батлагдсан болон сэжигтэй тохиолдлын 27 иргэнийг илрүүлж, 1000 гаруй иргэнийг халдвараас урьдчилан сэргийлэх, ажиглалт, тандалт, хяналт, тусгаарлалтад авч, 20 гаруй төрөлжсөн нарийн мэргэжлийн чиглэлээр 380 гаруй иргэн, үйлчлүүлэгчдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж, давхардсан тоогоор 650 гаруй эмч, сувилагч, эмнэлгийн ажилтан 14-21 хоногийн хугацаатайгаар 14 удаагийн ээлжийн үүрэг гүйцэтгээд байна.

Эрүүл мэндийн болон Батлан хамгаалахын сайдын хамтарсан 2020 оны "Эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах тухай" А/547, А/279 дүгээр тушаалын дагуу Улаанбаатар хот, Сэлэнгэ аймагт голмтлон гарсан болон Дархан-Уул, Орхон аймагт гарсан "Ковид-19"-ийн батлагдсан 404 тохиолдлыг хүлээн авч, эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлсэн бөгөөд өнөөгийн байдлаар 201 хүнийг эмчлэн эдгээгээд байна.

БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖИЛ ӨРНӨСӨӨР ...

Манай улс сүүлийн жилүүдэд улсын эдийн засгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэх төмөр зам, авто зам, газрын тосны үйлдвэр зэрэг стратегийн томоохон бүтээн байгуулалтыг өрнүүлж, үүнд дотоодын ажиллах хүчнийг оролцуулах, өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан хэрэгжүүлэх бодлогыг баримталж байгаа бөгөөд бүтээн байгуулалтын ажилд Зэвсэгт хүчний барилга-инженерийн цэргийн анги, салбар, цэргийн алба хаагчид оролцож, хүлээлгэсэн үүргийг богино хугацаанд, бага зардлаар, чанартай гүйцэтгэж байна. Тухайлбал, энэ онд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.1 км төмөр замын бүтээн байгуулалтын ажилд оролцож, 25,474,934.1 м.куб газар шорооны ажил, 594 хэсэгт үерийн ус зайлуулах хоолой, 27 хэсэгт гүүрийн барилга угсралтын ажил, зургаан хэсэгт зөрлөгийн барилга, Өмнөговь аймгийн Цогтцэций сум орчмын өртөөний барилгын ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Түүнчлэн нийслэл Улаанбаатар хотын хөрөнгө оруулалтаар Зэвсэгт хүчний 303 дугаар ангийг хотын төвлөрсөн дулаан хангамжид холбох ажлыг бүрэн хэрэгжүүллээ. Ингэснээр тус ангийн алба хаагчдын ажлын орчин нөхцөл сайжирсны зэрэгцээ хотын агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмрээ оруулсан арга хэмжээ боллоо.

ГАЛТ ХЭРЭГЛЭЛИЙГ АЮУЛГҮЙ БОЛГОХ ТУСГАЙ БАЙГУУЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЖИГДРҮҮЛЛЭЭ

Артиллерийн гүйцэтгэн цэнэглэсэн галт хэрэглэлийг аюулгүй болгох тусгай байгууламжийн аюулгүй байдлыг хангах, үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар өргөтгөн зохион байгуулж, тусгай ангийн зэрэглэлтэй болгон, 123,0 сая төгрөгийн үнэ бүхий техник, тоног төхөөрөмж, материал хэрэгсэлээр ханган үйл ажиллагааг нь жигдрүүлээд байна.

Тусгай ангийг байгуулснаар тэсрүүлэгчийн хадгалалтын баталгаат хугацаа дууссан, цаашид аюулын эрсдэлийн зэрэглэл өндөртэй галт хэрэглэлийг үйлдвэрийн аргаар дахин боловсруулж, учирч болох гэнэтийн осол, аюулаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой болсон.

ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭРИЙН ДАГУУ 591 АЙЛЫН ОРОН СУУЦЫГ ОФИЦЕР, АХЛАГЧ, АЖИЛТАН АЛБА ХААГЧДАД ХӨНГӨЛӨЛТТЭЙ ҮНЭЭР БОЛОН ҮНЭГҮЙ ХУВЬЧИЛЛАА

Засгийн газрын 2020 оны "Орон сууц хувьчлах тухай" 56 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Батлан хамгаалахын сайдын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн тушаалаар энэхүү ажлыг зохион байгуулах Ажлын хэсгийг байгуулж, ажиллалаа.

Албан тушаалын орон сууцыг хувьчлах хөнгөлөлттэй үнийг тогтоож, хувьчлах ажлыг богино хугацаанд хэрэгжүүлснээр 591 офицер, ахлагч, ахмад дайчин, ажилтан алба хаагчдад амьдарч байгаа албан тушаалын байрыг нь хөнгөлөлттэй үнээр /562/ болон үнэгүй /29/ хувьчилж өгсөн нь тэдний нийгмийн хамгааллыг дээшлүүлэхэд бодит алхам боллоо.

"ЖИШИГ ХОТХОН ТӨСӨЛ"-ИЙГ ЭХЛҮҮЛЛЭЭ

Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнайгаар ахлуулсан ажлын хэсэг баруун бүсэд байрлах Зэвсэгт хүчний есөн анги, таван салбарын үйл ажиллагаа, барилга байгууламж, алба хаагчдын нийгмийн хамгаалал, ажиллаж амьдрах нөхцөл байдалтай танилцаж, улмаар Зэвсэгт хүчний 016, 123, 234 дүгээр анги, Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 116 дугаар салбарыг орчин үеийн хэв маягийг харуулсан инженерийн шинэлэг шийдэл бүхий "Жишиг цэргийн хотхон" болгох саналыг Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлээ.

"Жишиг цэргийн хотхон" төслийг хэрэгжүүлснээр Зэвсэгт хүчний хэмжээнд баригдаж буй барилга, байгууламжууд орчин үеийн нэгдсэн стандарт, хэв маягтай болох, сургалт, дадлагыг зохион байгуулах, ажиллаж амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх юм.

ЗЭВСЭГТ ХҮЧИН-100 ЖИЛ

Монголчууд бид бахархах амжилтын 100 жилийн түүхээ дурсан багдаж, судалж, өгүүлж байгаа билээ. Үнэхээр ч гайхалтай түүхийг бидний өвөг дээдэс маань бүтээж дээ. Өнөөдрийн бидэнд үлдээсэн Монгол Улсын тусгаар тогтнол, эрх чөлөөг эрхэмлэн дээдэлж, хөгжүүлж, үр хойчдоо өвлүүлэх хариуцлагатай үүргийг үүрэлцэж яваа олон зуун хүний нэг болохын хувьд түүхэнд тэр болгон дурдагдаж байгаагүй Ардын намын цэргийн анхны тулалдаануудын тухай өгүүлье.

Монголын хувьсгалт байгууллагын төлөөлөгчид Зөвлөлт Орос Улсаас тусламж олоод 1920 оны 11 дүгээр сарын сүүлчээр Дээд Шивээд буцаж ирмэгц Ардын намд гишүүн, цэрэг элсүүлэх, намын анхдугаар их хурлыг хуралдуулах, Хувьсгалт түр засгийн газрыг байгуулах, харийн түрэмгийлэгчдийн эсрэг нийт ард түмний зэвсэгт бослогыг зохион байгуулах талаар ихээхэн ажлуудыг шаргуу хийж байлаа. Тэд Дээд Шивээг Монголын ард түмний үндэсний эрх чөлөөний тэмцлийн төв болгож Ардын намын цэрэг элсүүлэх зэрэг хувьсгалын ажлыг зохион



Пулемёт ангийн захирагч Ч.Дамдинсүрэн



МАН-ын цэргийн анхны хорооны дарга Б.Пунцаг



Цэргийн лам Ц.Хасбаатар

МОНГОЛ АРДЫН НАМЫН ЦЭРГИЙН АНХНЫ ЯЛАЛТУУД

байгуулжээ.

Хойд зүгийн хошуу, харуулуудын ардууд намын уриаг халуунаар угтан авч Ардын намын цэрэгт сайн дураараа элсэн орох болжээ. Д.Сүхбаатар, Хиагтын зүүн дөрвөн /Хяраан, Чагтай, Уялга, Хүдэр/ харуулаар явж намын бодлогыг сурталчлан Ардын намын цэрэг элсүүлэх ажлыг зохион байгуулжээ. Тэдгээр харуулын эрчүүд эрх чөлөөний төлөө тэмцэлд зүтгэхээр сайн дураараа эвлэлдэн орсны дотор Хяраан харуулын занги Содномын Дамдинсүрэн, "чавганц" хэмээх Бадрах, Цэдэнбалжир, Хасбаатар, "ам" хэмээх Б.Содномдаш, Уялга харуулын нутгаас Лувсандамдин, Г.Самдан, Ц.Чимид, Бүдрагчаа, Р.Мөнхжаргал, М.Лугтаа, Сэрдамба, Ж.Жамсран, С.Загд, З.Дэмбэрэл, "журам" хэмээх Д.Дамба нарын 11 хүн (ланжуу буу 8, хувийн уналга морьтой)-ийг элсүүлж, Ар булаг хэмээх газар хуралдуулжээ.

Д.Сүхбаатарын даалгаснаар Цэдэнбалжир, Хасбаатар нар Хүдэр харуулын нутгаас Дашням, Түвдэннамсрай, Дамдин начин, А.Цогт, Лувсанчүлтэм нарын 8 хүнийг элсүүлжээ. Эдгээр хуралдсан цэрэг бүгд 19 болж, 1921 оны 2 дугаар сарын 18-ны өдөр Хяраан харуулын Цагаан бургас гэдэг газар занги С.Дамдинсүрэнгийн дугларчээ. Д.Сүхбаатар сайн дураар элсэн хуралдсан журамт нөхдийг байнга анхааран халамжилж, зохион байгуулалтыг нь бэхжүүлэн шууд удирдаж байлаа. Д.Сүхбаатар зүүн харуулуудаас буцаж ирмэгц, 1921 оны 2 дугаар сарын 19-ний өдөр Хиагтад байсан Б.Пунцаг, Л.Дарьжав, Д.Нанзад, Н.Бямбаа, хуурч Гавар, Д.Дашзэвэг, М.Бавуу, Ц.Жигжид,Өсөх, их Цэнд, бага Цэнд, Дандар нарыг Дээд Шивээнд дуудан ирүүлжээ. Энэ үед Х.Чойбалсан тэргүүтэй хувьсгалчид Эрдэнэ ван Намсрай, бэйс Сумъяа, Хатанбаатар ван Магсаржав нар хошуу нутагт ард түмний дунд намын суртал бодлогыг нэвтрүүлэх, Ардын намын цэрэгт хүн элсүүлэх ажлыг хийж байлаа.

Хувьсгалт үйл ажиллагааны төв Дээд Шивээ орчинд цэрэг-улс төрийн байдал цаг тутам хүндэрч байгааг жанжин Д.Сүхбаатар мэдэрч гамингийн удирдлагын талаас бүх талын хяналт, тагнуул, туршуулын сүлжээ үүсгэсэн байгааг тооцож, журмын нөхдөдөө байнга сануулан өөрийн тагнуулын үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж байжээ. 1921 оны 2 дугаар сарын 18-ны үед Манжийн үеийн Хиагтын харуулын албанд цэргийн алба хаасан, гурван төрийн нүүр үзэж байгаа орон нутгаа арван хуруу шигээ мэдэх Ч.Сандаг нарын нөхдөд "... бидний журмын цэргүүд, гамингийн тагнуулуудыг Хиагтаас зүүн тийш Хяраан, Чагтай, Хүдэр, Уялга зэрэг дөрвөн харуул руу явах их замаар нааш, цааш явж буй эсэхийг сайн тагнаж байх хэрэгтэй" гэж тушаасан юм. Тушаал ёсоор Ч.Сандаг, "баавгай" Ринчин, Дагва нар Хайлаастын элсний ар гэдэг газар тагнаж явтал нэгэн морин тэрэгтэй гамин явж байгааг илрүүлжээ. Орос улсын замын харуул нэгэн оростой хамт дөрвүүлээ түүнийг барьж авах гэж тэр гамин орос цэргийн салмийг булаан авч Дагва, Ринчин, "орос" цэрэг гуравтай зууралдан ноцолдож байхад нь Ч.Сандаг зай завсрыг харж байгаад буудаж хөнөөгөөд нэгжин үзэхэд тэр гамингаас үнэтэй мэдээлэл агуулсан баримт бичиг гарч жанжны даалгаврыг сайн биелүүлж байжээ. Цагаан бургаст намын цэрэгт элсэгчид цугларч байхтай зэрэгцээд гурван морь хөллөсөн дөрвөн дугуйтай тэрэгтэй хоёр гамин зүүн талын Цагаан бургас гэдэг газар айлуудаар ирснийг сонсоод занги С.Дамдинсүрэн жанжин Д.Сүхбаатарын тушааснаар зохион байгуулан тэр хавийн 20 гаруй хятад иргэдийн хамт барин байцавал, тэрэгтэй хоёр хятад нь тагнуул байсныг илрүүлэн барьжээ.

Энэ үйл явдалтай зэрэгцээд намын цэргүүд зүүн харуулуудаар /2 дугаар сарын 18/, наймаа хийж явсан, Хиагтад пүүстэй 7 хятадыг баривчлан авч, Хярааны голын баруун элсэнд аваачаад давхардуулан

зогсоож байгаад сумаа хямгадан 4 буудаж, цөм үхсэн гэж бодоод орхисон чинь 6 нь үхээд, Лаатууз /Сэрээтэр хэмээх монгол авгайтай/ гэдэг нэг хятад үхсэнгүй, тэр шөнөжингөө явган гүйсээр Хиагтад очжээ. Намын цэргүүд тэр 7 хятадыг Хиагтад очиж, Хяраанд цэрэг цуглаж байгаа мэдээг гаминд хэлчих байх гэж бодоод тийнхүү устгасан байдаг. Үнэхээр ч өнөө Лаатууз Хиагтад очиж мэдээлсэн учир түүний маргааш нь гамингууд Хяраан харуулын нутаг Гүн нуурын баруун хойд Өндөр хүр гэдэг газар өвөлжиж байсан Цэрэнпил гүнийд довтлон иржээ. Гүн нуур гэж Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын төвөөс зүүн урагшаа 9 км зайд, Хярааны голын зүүн гарт орших ба энэ нутгийн хойд талд буй Өндөр хүрдэд байсан гамин цэргийн давуу хүчний өөдөөс Монгол ардын намын цэргийн анхны отряд Б.Пунцаг, Ц.Хасбаатар нарын удирдлагаар 1921 оны 2 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд 3 удаа анхны тулалдаануудаа хийсэн түүхэн газар юм.

Намын цэргүүд 7 гамин хөнөөсөн шөнөө айлуудаар таран хонголож байтал 19-ний үүрээр Цэрэнпил гүний хүргэн Абидеев морьтойдовтлониржж: "...Манайхааргаминирж сүйд хийж байна. Туслаарай ..." гэсэн мэдээг хүргэмэгц Ц.Хасбаатараар удирдуулсан Монгол ардын намын цэргийн анхны отряд Цэрэнпилийнд довтлон очтол, тэдний зүүн талын элсэн дээр 2-3 гамин харуулд зогсож байсныг буудан хөнөөгөөд цааш давшин хэд хэдэн гаминг буудан алсан бөгөөд үлдсэн нь Хиагт руу зугтав. Цэрэнпилийнд очтол түүний эхнэр Дондогуламыг тэрэгний нэг дугуйнаас, тэднийд зарагддаг Шар Дархан гэдэг хүнийг тэрэгний нөгөө дугуйнаас хүлсэн, Цэрэнпилийн төрсөн хүүхэд Цогнар өвсөнд орж нуугдсан байсныг сулласнаар намын цэргийн харийн дайсангай хийсэн анхны тулалдаан ялалтаар төгсөв. Тэд гамин цэргээс 7-8-ыг алж, тав зургаан бамлий буу, 600 сум бас гамингийн туг, далбааг олзлон авчээ.

Анхны энэ тулалдаанд намын цэргүүд хувьсгалын төлөө юу ч хийхээс буцахгүй дайчин нөхөд байсныг Д.Нанзад нарын барьсан ташуураас өөр зэвсэггүй хэд хэдэн нөхөд хороосон гамингийнхаа зэвсгээр зэвсэглэн байлдаж ялалт байгуулсныг "Эрэлхэг Монголчууд" гэхээс өөрөөр юу гэлтэй билээ. Тэр гамингууд гэдэг чинь бэлтгэгдсэн цэргийн салбар шүү дээ. Бас ч үгүй 1920 оны 10 дугаар сарын сүүлчээр Бароны цэрэгтэй байлдсан, 1921 оны 2 дугаар сарын 4-ний өдөр нийслэл Хүрэнээс хөөгдсөн байлдааны туршлагатай билээ. Гамингийн цэрэг тугтай байсныг бодохоор зүгээр нэг жигмхэн тасаг, бүлэг биш, 40-50 хүнтэй салбар байсан гэж партизанууд дурссан байдаг. Тулалдаануудын байдлаас харахад, тэд ямагт тугтай байсан нь олон түмэнд цэргийн сүр үзүүлж, дайтаж байгаа тал, нийгмийн сэтгэл зүйг дарамталж байсны илрэл хэмээн үзэж болохоор байна.

Тулалдааны дараа Д.Нанзад Дээд Шивээнд очиж болсон үйл явдлын талаар Д.Сүхбаатарт мэдээлэхэд тэрээр долоон хятад иргэнийг хөнөөж, буун дуу гаргасан асуудлыг буруутгаад, гүн Цэрэнпилийн өвөлжөөнд болсон тулалдаан, ялалтыг сайшааж, тэнд зэвсэггүй байгаа цэргүүдэд хангалт хийж, Б.Пунцаг, Ч.Дамдинсүрэн нарын арав гаруй хүнийг хүч нэмэгдүүлэн байлдааны үүргээр ханган явуулжээ. Намын цэргүүд зэвсгээр хангагдан, пулемёттой, ганц хоёр цэрэг гранаттай болоод байрандаа очоод хонотол маргаа нь Д.Сүхбаатар ирж журмын нөхөд өоод зохион байгуулалтад орох хэрэгтэй гээд Ардын намын цэргийн хороог байгуулж, Б.Пунцагийг хорооны даргаар, Дүйн хорын да лам Ц.Хасбаатарыг цэргийн ламаар, Пулемёт "Кольт"/ бууны даргаар Ч.Дамдинсүрэн нарыг томилжээ.

1921 оны 2 дугаар сарын 21-ний өдөр гамингууд хүч сэлбэж мөн Цэрэнпил гүний өвөлжөө орчмоор дахин довтлон ирэв. Манай цэргүүд тосон байлдаад хүчин тэнцвэргүй байсан ч санаачилгыг гартаа авч тулалдаанаа түр завсарлан оройдоо хориглон

хонгоод 2 дугаар сарын 22-ны өглөө болоход гамин хүчээ нэмэгдүүлэн Хайлаастын өвөр гэдэг газраас гүн Цэрэнпилийн зуслан Гүн нуурын Дов хүртэл өргөн зурваст 200 гаруй цэргийн хүчийг байрлуулсан байлаа. Энэ тулалдаанд Д.Сүхбаатар дайсны цэргийг ов мэхээр нуувчаас нь гаргах төлөвлөгөөг боловсруулж Б.Пунцаг, Ц.Хасбаатар нарт үүрэг өгч, Ч.Сандаг, долоон хүзүү Цэнд нарын гурван цэргийг баруун хойноос нь довтлуулж, дайсны өвөр эгнээнд хүргээд буцааж зугтаалган дайснаар нэхэн хөөлгөж, бэлтгэсэн зурваст ирүүлэн ихээхэн хүчийг дарсан ч олны хүчээр (... Эхний эгнээг устгахад хоёр дахь эгнээ давшиж байлаа гэж партизан Д.Дагва дурсжээ) дайсан хүч түрэн довтолсноор манай цэрэг ухран Орос Хярааны харуулаар Цөх голын баруун тал дахь Хутаг-Өндөр уулыг чиглэн ухарч Зөвлөлт Оросын нутагт ирж тулалдааныг хохиролгүйгээр дуусгасан байлаа.

Тэргүүн хорооны аравтын дарга, партизан Ч.Сандаг "Манай нэг нөхөр нэгэн өндөрлөг газраас гурван удаа гамин руу буудсан юм. Ажиглаж харвал гамин цэрэг байсан газарт дөрвөн хар юм үлдэн хоцорчээ. Тэр нь гамингийн шархатсан цэрэг байжээ. Түүнийг мэдээд манайхан цөм буудахыг завдав. Гэтэл манай дарга /Садын Балдир боллоотой. М.Б./ буудахыг хориглож, миний гранатыг авч тэр рүү чиглүүлэн хаялаа. Гранат тэсрэн нам гүм болсны дараа бид очиход гамингийн туг барьсан хоёр цэрэг үхсэн байлаа" гэж дурссаныг үзэхэд тэд Ч.Дамдинсүрэнгийн нэг пулемёт, цөөн тооны гранаттай байжээ. Д.Нанзад баатрын дурсамжаар "... Түүний морь нь эцээд сандарч явахад цуг байлдаж явсан Бадрах гэгч мориндоо сундалдаад хамт тулалдааны талбараас гарахгүй сайн мориндоо мордоод ганцаараа явснаас Нанзад морио орхиод эмээлээ үүрэн арай гэж Оросын харуулаар орж иртэл, Оросын харуул бүх зүйлийг шалган буу зэвсгийг хураан хил нэвтрүүлж нэгэн өрөөнд оруултал тэнд Цэнд байж, хоёул уулзалдан юу болсноо ярилцаж, буу олон удаа дуугарсан, зарим нь үхэж, хэд нь зугтан гарч чадсан болов уу гэж ярилцан, ийш тийшээ хартал мөн суурины зүүн хойд талын өндөр овооны хөтлөөр шар тугтай морьтой цэрэг ирж яваа харагдав. Нөгөө Цэнд энэ манай цэрэг зугтан гарч ирж байгаа болов уу, өөр шар тугтай цэрэг юу билээ. Лав манай цэрэг байх гэж ярилцан байтал тэр цэрэг ойртон иртэл, тэд манайхан мөн байлаа. Нөхөр Б.Пунцаг нар тоогоороо бүрэн байлаа" гэснээс харахад намын цэргийн анхны хороо шар тугтай байсан байна. Олон дахин давуу хүчтэй дайсангай бэлтгэл зохион байгуулалт муутай сайн дурынхны хийсэн тулалдаанд хохиролгүй гарна гэдэг үнэхээр бахархмаар.

Дөнгөж байгуулагдсан анхны өдрүүдэд Ардын намын цэрэг, гамин цэрэгт дээрэмдүүлэн хүчирхийлүүлж байсан энгийн номхон иргэдийг хамгаалан гамин цэргийн бүлгүүдтэй удаа дараа тулалдан ялж, хүч тэнцвэргүй тулалдаан хийсэн нь Ардын намын цэргийн алдар хүндийг эрс дээшлүүлж, түүний эгнээ түргэн өсөхөд түлхэц болжээ.

Хиагт хавиар цаашид улам аюултай болох учир зүүн харуулын намын цэрэг Д.Сүхбаатарын заавраар Орхон, Сэлэнгийн бэлчир Алтан хэмээх газар хүрэлцэн иржээ.

Намын цэрэг элсүүлж, зэвсэгт бослогод бэлтгэх ажил эрчимтэй өрнөж байлаа. Гүн Цэрэнпилийн нутгаар болсон тулалдаануудын дараа Алтан хавиар байрласан цэргүүдийн бэлтгэл сургуулилт хийлгэж байгаа үед тэдний бэлтгэлийг шалгасан нэгэн тулалдаан болсон нь "Дайтунгийн Өлөнтийн тулалдаан" юм. Шаамарын Шар тохой (Дайтунгийн өлөн, Тайны арал, Оросын тавилан) Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотоос урагш 16 км зайд орших Орхон голын нэгэн томоохон битүүг ийнхүү нэрлэнэ. Ардуудын хадаг бэлтгэсэн өвсийг дээрэмдэж байсан 200 гаруй /зарим партизануудын дурдатгалд 400 гэсэн байдаг/ гамин цэргийг Д.Сүхбаатарын захирсан монгол ардын намын цэргүүд 1921 оны 3

дугаар сарын 10-ны өдөр Цагаан арал, Элст Мэргэний татуур, Далангийн ам, Хар усны бургас, Чавганцын тохой, Орхоны зүүн тал, Бор гүвээ зэрэг газраар бүслэн авч, дайсны давуу хүчтэй Дархитын ар, Өвсний хонхор, Дайтунгийн өлөнтөд ширүүн тулалдаан явуулсны эцэст тэднийг бут цохиж ялалт байгуулсан.

Энэхүү тулалдаанд Б.Пунцагаар удирдуулсан цоохор цэрэг, Эрдэнэ вангийн хошууны Бумцэндээр удирдуулсан 90 шахам тооны цэрэг дуудагдан ирсэн билээ. Энэ үед баатар Д.Нанзад Хиагт хавиас 10 гаруй цэрэг элсүүлэн ирж таарсан юм. 1921 оны 3 дугаар сарын 10-ны өдөр ардуудын өвсийг дээрэмдэж байгаа мэдээ авсан Д.Сүхбаатар айлын өвөлжөөнд байгаа гамингуудыг Орхон голын зүүн гар талаар Пунцагийн цэргийг, баруун гар талаар нь Бумцэндийн цэргийг байрлуулан бүслэж, дайсны хорооны дарга (байчиян)-тай уулзахаар Д.Нанзад, Н.Лаасаг (хятад хэлтэй), Д.Дашзэвэг нарыг дагуулаад гамингуудын дундуур яван очтол, гамингийн ноён агсам хээр морин дээр хөндөлдөн маузараа хуйнаас нь омогтойгоор гарган сүр үзүүлэхэд, Сүхбаатар "Чи буудалцах хэрэггүй, буу битгий дуугарга, ярилцах хэдэн үг байна" гэхэд Байчиян (хороон дарга) "Чи хэний цэрэг вэ" гэж омогтойгоор асуув. Сүхбаатар "Бид цагаан Бароны цэрэг биш. Ардын намын цэрэг. Бид урьд хожид та нартай дайн, байлдаан хийж яваагүй. Өс хонзон байхгүй. Гэтэл яагаад байлдаж гэж байгаа вэ гэвэл, бид ард түмний амгалан тайван байдлыг алдагдахуулахгүйг хүсдэг. Та нар манай ардын амгалан тайван байдлыг алдагдуулж, ардын хадлан өвсийг хэний ч зөвшөөрөлгүйгээр ачиж байгаа тул бид байлдахаар ирж та нарыг бүслэв. Чи одоо буу зэвсгээ хураалга" гэж Лаасаг хэлмэрчлүүлэн хэлтэл, Байчиян маузераа унжуулаад "Би дээд даргын тушаалгүйгээр буу зэвсгээ хураалгахгүй" гэсэнд Сүхбаатар "Зүйтэй, аливаа цэргийн хүн буу зэвсгээ амь мэт хайрладаг байна. Иймд бид байлдана. Манай цэрэг чамайг бүслээд байна. Чи аль чадахаараа байлд" гэж хэлээд моринхоо амыг эргүүлэхийн хамт цэрэгтээ гал нээх дохио өгөөд байлдаанд оржээ. Партизан Д.Дашзэвэгийн дурссанаар "... Сүхбаатар бидэнтэй байлдаанд орохдоо маузераа барьж өөрөө уухайлан ордог тийм эрэлхэг зоригтой хүн байсан. Сүхбаатар байлдаанд ухрахгүй ба дайсныг заавал сөнөөх тухай хатуу тушаал өгч, өөрөө дайнд түрүүлэн ордог, уриа хийж дайрах их дуртай. Байлдаж байх үед ухарч буцаж байтугай цэргийн хүнд эргэж харах ч цаазтай гэж олон дахин сануулдаг байж билээ." гэжээ.

Энэ байлдаанд баатар Д.Нанзад сайн байлдаж, хорооны даргыг хөнөөж түүний морь /орос тоомсог/, буу, ганзаганы хүнстэй нь олзлов. Орой нь Данзан ламын дунд тулалдааны дүн гаргаж Д.Сүхбаатар баатар Д.Нанзадад байлдаанд гаргасан эр зориг, баатарлаг тулалдсан гавьяаг нь үнэлж өөрийнх нь олзолсон морь, маузер бууг шагнал болгон урамшуулсан нь жанжны удирдлагын шуурхай, нягт намбай байдлыг илтгэнэ. Маргааш нь тулалдааны талбарыг шалгахад 80 гаруй гамингийн цогцос байсан гэхээр гамин 400 орчим байсан бололтой. Хиагтыг чөлөөлөх их үйл хэргийн өмнө дайчдыг зоригжуулсан бөгөөд жанжны нэр төрийг ард түмэн, цэргүүдийн дунд өндөрт өргөсөн Дайтун Өлөнтийн тулалдаан намын цэргийн сүүлчийн тулалдаан байлаа.

Ардын намын байгуулалт эрчимтэй өргөжин 1921 оны 3 дугаар сарын 12-ны өдөр Дээд Шивээ (Троицкосаяск)-нд Монгол ардын нам, Ардын намын цэрэг, хошуу шавийн төлөөлөгчийн хамтарсан хурал болж, Монгол ардын намын анхдугаар их хурлын заалтыг удирдлага болгон зэвсэгт бослогыг удирдах төв байгууллага Ардын түр засгийн газар ("Монгол ардын засгийн хэргийг түр захиран шийтгэх газар")-ыг Д.Сүхбаатар, Х.Чойбалсан, Л.Сумъяа, Н.Билэгсайхан нарын долоон хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, Ардын намын цэргийн штабыг шинэчлэн Бүх цэргийн дэд жанжинд Л.Сумъяа, намын суртлын номлогчоор Х.Чойбалсан, Ц.Дамбадорж нарыг томилж, 3 дугаар сарын 12-ны өдрөөс намын цэргийг "Ардын журамт цэрэг" хэмээн нэрийдсэнээр цэргийн мэргэжлийн удирдлага нь Засгийн газарт шилжиж намын цэрэг нь Бүх ардын цэрэг болсон түүх ийм болой.

Монгол цэргийн музейн ахмад ажилтан, судлаач М.БЯМБАРАГЧАА

Залуус

Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн Нисгэгчгүй нисэх системийн судалгаа, туршилтын төвийн дарга, ахлах дэслэгч И.ЗОРИГТОЙ ярилцлаа.

Уншигчдад өөрийгөө товч танилцуулна уу?

-Би 1990 онд Дорнод аймагт төрсөн. Нийслэлийн Ерөнхий боловсролын 2 дугаар дунд сургуулийг 2007 онд төгссөн. Тэгээд 2008 онд ҮБХИС-д элссэн юм. ҮБХИС-д нэг жил суралцаад шалгалт өгч, тогтоосон шалгууруудыг нь хангасны эцэст Оросын Холбооны Улсад суралцах боломж нээгдсэн. Ингэснээр Н.Е.Жуковский, Ю.А.Гагарины нэрэмжит Агаарын цэргийн инженерийн академийг нисэх аппаратын хөдөлгөөр, их биеийн ашиглалтын инженер мэргэжлээр суралцаж төгссөн.

Анхны томилгоо хаанаас хэзээ эхэлсэн бэ?

-2015 онд төгсөж ирээд Зэвсэгт хүчний 303 дугаар ангид борттехникчийн албан тушаалд, удалгүй ҮБХИС-д тус тус томилогдон ажилласан. Өнгөрсөн хавраас Зэвсэгт хүчний 337 дугаар ангид

мэтгэлцэх ур чадварын талаарх ойлголтыг сонсогч болон "Тэмүүжин Өрлөг" сургуулийн сурагчдад өгөхийг зорьж ажилласны дүнд тодорхой ахиц дэвшил гарсан гэж боддог. Жишээлбэл, сургуулийнхаа анхны аваргыг тодруулсан тэр жилдээ клуб маань оюутны улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцож байлаа. Манай сургуулийн оюутнуудын хувьд анх удаа улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцсон нь тэр. Би одоо клубийнхээ чиглүүлэгч багш гэсэн статустай. Илтгэх урлаг, мэтгэлцээнээр хичээллэснээр бусдад өөрийгөө илэрхийлэх, таниулах, талуудын харилцан ойлголцлыг дээшлүүлэх, зөв цэгцтэй, системтэй ярьж сурах зэрэг чадварт суралцдаг онцлогтой. Тиймээс энэ чадварт суралцах хөрсийг нь бэлдэх үүднээс "Давах цаг" клубийг үүсгэн байгуулах санаачилгыг гаргасан. Залуу



сурахаар мэдээллийг олон сувгаас олж авна, түүндээ үндэслээд бас дүн шинжилгээ хийдэг болно. Тиймээс би англи хэлийг бүр мэргэжлийн түвшинд эзэмших зорилго тавьсан. Энэ зорилгодоо нэг алхам ойртохын тулд Энэтхэгт очиж суралцахаар явсандаа их олзуурхдаг. Энэ нь надад маш том хөрөнгө оруулалт болсон гэж боддог. Их урамшсан. Одоо цаг ямагт л туштай судалж, суралцаж байна. Өөрийгөө бас хэд хэдэн удаа сориод амжсан. ҮБХИС-ийн байнгын бие бүрэлдэхүүний дунд зохион байгуулсан англи хэлний олимпиадад гуравдугаар байр эзэлсэн. Мөн Улаанбаатар цэргийн хүрээний Зэвсэгт хүчний ангиудын хүрээнд зохион байгуулсан орос хэлний олимпиадад дэд байрт шалгарсан амжилтыг үзүүлээд байна.

Ахмад үе нь залуустаа үлгэрлэж, бусдыгаа манлайлах замыг нь нээж, засаж өгдөг байгаасай гэж хүсдэг. Хариуд нь залуусыг ямар байгаасай гэж хүсдэг вэ?

-Сайн даргатай олон таарч, удирдлагад нь заавар, чиглэл авч

И.Зориг: ХҮН ХЭЦҮҮД НЬ ДУРЛАВАЛ ...

Нисгэгчгүй нисэх системийн судалгаа, туршилтын төвийн даргаар ажиллаж байна.

Өөрийгөө хэр бүтээлч оюутан байсан гэж боддог вэ?

-Туршилтын стэнд зохион бүтээж байсан. Хөдөлгүүрийн хэлбэлзлийн төрлүүдийг тогтоодог төхөөрөмж гэсэн үг л дээ. Түүгээрээ академийнхаа хэмжээнд уралдаан, тэмцээнүүдэд оролцсон. Дараа нь улам боловсронгуй болгож дипломын ажлаа хамгаалсан.

"Давах цаг" клубийг үүсгэн байгуулах санаа яаж төрсөн бэ? Бусад их, дээд сургууль оюутан төвтэй мэтгэлцээний клубтай болоод багагүй хугацаа өнгөрсөн л дөө ...

хүний хувьд шинийг сэдэж, эрэлхийлж, хийх гэж оролдсон минь энэ. Одоо оюутнууд маань клубийнхээ үйл ажиллагааг өөрсдөө аваад явахаас гадна уралдаан тэмцээнд амжилттай оролцсоор байна. Товчхондоо ийм.

Цэргийн хүн болох шанг тань ойр дотнын хэн нэгэн чинь татсан байх. Танай удамд цэргийн хүн олон байдаг уу?

-Өвөө маань Лүйжир гэж хурандаа байсан. Төв аймгийн Цэргийн штабын даргаар ажиллаж байсан. Тэр чиглэлээр ОХУ-д бэлтгэгдсэн анхны гурван хурандаагийн нэг нь. Өвөөгийнхөө талаар өөр зүйл мэдэхгүй. Би хүүхэд

өөртөө тавьсан нэг томоохон зорилт байсан. Гадаадын их, дээд сургуульд суралцаж, өндөр боловсрол эзэмших боломж нь илүү нээлттэй юм шиг санагдсан. Дээр хэлсэнчлэн ҮБХИС-д суралцсан эхний жил шалгалт өгч тэнцээд ОХУ-д үргэлжлүүлэн суралцсан. Цэргийн сургуульд суралцсан зургаан жил намайг мэргэжилд минь дурлуулж, бахархах сэтгэлийг төрүүлсэн шүү.

Гэр бүлээ товч танилцуулахгүй юу?

-Эхнэр, хоёр хүүхэдтэй. Одоогоор тэд маань Эрдэнэт хотод амьдарч байна. Цаг үеийн нөхцөл байдал хүнд байгаа болохоор уулзаж чадалгүй 3 сар болжээ.

Тангараг өргөсөн мөрдэстнүүдийнхээ ажил албыг эхнэрүүд нь хамгийн их ойлгодог. Цэргийн хүний гэргийг эх орон, төр, ард түмэндээ эр нөхөртэйгөө хамт тангараг өргөсөн эгэлгүй тавилантай ч гэж хэлдэг ...

-Цаг ямагт дэмжиж, ойлгодог хүмүүсийн нэг бол эхнэр маань. Хийсэн сонголтыг минь өөрийнх шигээ хүндэтгэн хүлээж авдаг хань Ц.Ганчимэгээр ямагт бахархаж явдаг.

Өвөөгөө цэргийн хүн байсан гэж ярьсан шүү дээ. Тэгвэл аав, ээж хоёр тань ямар мэргэжилтэй хүмүүс байдаг талаар сонирхъё ...

-Аавыг маань Л.Идэрзана гэдэг. Инженер, эдийн засагч хэмээх хос мэргэжилтэй. Оросын Эрхүү хотод сурч байсан юм билээ. Сүүлд шатрын багш болчихсон. Шатрын спортоор улсын аварга болж байсан юм. Аав тэтгэвэртээ гарснаас хойш сонирхлоороо л ажиллаж байна. Харин ээж Л.Алтанцэцэг урлагийн хүн. Багадаа балетаар хичээллэдэг байсан, МҮОНРТ-ийн "Алтан сан" хөмрөгт бүжиглэж байгаа бичлэгүүд нь хадгалагдаж үлдсэн юм билээ. Одоо телевизэд дуу оруулагч жүжигчнээр ажилладаг. Ах, эгч нар маань ч инженер техникийн мэргэжил эзэмшсэн хүмүүс байдаг.

Инженерийн гэр бүлийн онцлог их харагддаг байх нь ээ ...

-Системтэй бодох ухаан. Ийм ухаан генээр дамжиж хүнд бий болдог байх. Аав маань шатрын аварга болж байсан тухай дээр хэлсэн дээ. Шатар сайн тоглодог хүнийг стратеги гэж хэлж болохоор. Тэд дараагийн нүүдлээ, түүний

дараагийнхийг ч бодож, хардаг. Миний хувьд инженерийн тооцоолон бодох ухааныг Цэргийн сургууль суулгаж өгсөн гэж боддог.

Тэгвэл Н.Е.Жуковский болон Ю.А.Гагарины нэрэмжит Агаарын цэргийн инженерийн академийн талаар үргэлжлүүлээд ярилцах уу?

-Сахилга, дэг журмыг хамгийн өндөр түвшинд байлгадаг сургууль. Суралцах хугацаандаа чөлөөгөөр гарч үзээгүй. Өглөөний гүйлт, гимнастикадаа үргэлж гардаг байлаа. Биднийг сургасан орос офицерууд гэж гялалзаж, гялтганасан, эрч хүчээр дүүрэн хүмүүс гэдгийг хангалттай мэдрээд ирсэн. Офицер хүн байх зарчимч чанар, удирдах ухаан гээд тэд их зүйлийг үлгэр жишээчээр зааж сургадаг. Өглөө бүр 05.00 цагт биднийг дасгал сургуулилт хийлгэхээр аваад явахад нь заримдаа эд нар эхнэр, хүүхэдгүй юм байх даа гэж ч бодож байлаа. (Инээв) Багш нарын арга барил, заах арга зүйн хувьд ч ялгаагүй гайхалтай. Тэд бидний инженер болох замыг дардан гэгч нь тавьж өгсөн. Системтэй боддог, прагматик сэтгэлгээтэй болж төлөвшихөд энэ сургууль мөн миний аливаа номыг дурлаж уншдаг маань нөлөөлсөн байх.

Гадаад хэл мэдэхгүйн зовлон алсдаа бидэнд чөдөр тушаа л болно. Энэ зовлонг бодитоор мэдэрч байв уу?

-Миний хувьд зургаан жил суралцсан болохоор оросоор гайгүй сайн ярьж, бичдэг болоод эх орондоо ирсэн гэж боддог байлаа. Нэг удаа Одон орон судлалын төвд зохион байгуулагдсан олон улсын хуралд оролцохоор очихдоо өөрийгөө сайн голсон доо. Бас тэндээс гарахдаа өөрийгөө чангахан шиг ташуурдах ёстой юм байна гэдгээ ойлгосон. Тэрхүү хуралд оролцсон хүмүүс хоорондоо англиар ярьж, мэдээллээ солилцож байсан. Тухайн үед миний англи хэлний мэдлэг гавихааргүй байсан тул тэдэнтэй эн зэрэгцэн ойлголцож чадахгүйгээ мэдээд шар хөдлөөд л гараад явсан. Дараа нь англи хэлийг сурахаар шийдэж төрөл бүрийн хэлбэр, сувгуудаар дамжуулан өөрийгөө шахаж, дайчилж эхэлсэн. Ингээд суралцах тусам хүн хэмжээ хязгаараа бага багаар мэдэрч эхэлдэг юм байна лээ. Бусад орнуудын үе тэнгийн офицерууд юу хийж байгаа бол гэдэг талаар их боддог болсон доо. Хэл

ажиллаж байсан. Одоо ч тэгж байна. Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн штабын даргаар ажиллаж байсан хурандаа Б.Энхзорголын ачаар ажилдаа гайгүй сайн дадсан гэж боддог. Намайг ажлаар сайн шахадаг байж билээ. Түүнийх нь ачаар ачаалалдааж, зохион байгуулж, төлөвлөж сурсан. Залуус бидний нийтлэг алдаа дутагдал нь залуурал. Алдаа дутагдал гүйцэд арилгахын тулд би өдөр бүр л залууралтайгаа тэмцэх гэж оролддог. Ер нь хүн явж, явж эцсийн дүндээ өөрөө өөрийнхөө л өрсөлдөгч гэж үнэн байх. Одоогийн байгаадаа сэтгэл хангалуун байвал хөгжихгүй гэдэг үг ч бас оргүй зүйл биш шиг санагддаг. Хэцүүд нь дурлаад, хийгээд сурчихвал бусад нь гарт хурдан ороод илүү хялбар санагдана биз дээ.

Эх орондоо өргөсөн тангарагтаа үнэнч байж үүргээ л сайн гүйцэтгэмээр байна. Ингэхийн тулд бага ярьж, их хийе. Ийм соёлд бага багаар суралцаж байгаа. Бас захирагч, дарга нарын хэлсэн санал, санаачилгыг ажил, үүрэг гэж ойлгодог байя. Түүнийгээ хэрэгжүүлбэ. Тэгвэл бид бусдаас маш олон зүйлийг суралцана гэж боддог юм. Бас ахмадуудын үгийг сонсох хэрэгтэй. Тэд өөрсдийнхөө гаргасан алдааг биднээр давуулахыг хүсдэггүй. Тэтгэвэр, чөлөөнд гарсан дарга нараас түүх, сургамжийг нь сонсьё. Мөн багаар ажиллаж чадвар хамгийн чухал. Хүн ганцаараа юунд ч хүрч чадахгүй. Амжилтыг хуваалцах хэн нэгэн үргэлж байдаг.

Танай ангийн байнгын бие бүрэлдэхүүний дийлэнх нь залуус. Хамгийн сайхан нь залуус ямар ч ихэрхэл, бас нэрлэхээ зангүйгээр бие биедээ нөлөөлж чаддаг байх зарчим ...

-Урамтай. Үүнийгээ дагаад хүндлэл, хариуцлага ч бас сайжирдаг. Мэдээж албаны ажил, харилцан ойлголцол, харилцаан дээр тулгуурлана. Бусдынхаа ажлыг цалгардуулж, хийдүүлэхгүйн тулд албан үүргээ гүйцэтгэхдээ өөрөөсөө шалтгаалах бүхнийг хийж гүйцэтгэдэг. Манай ангид гадна, дотнын орнуудад боловсрол эзэмшсэн инженер олон. Бүгд л өөр өөрийн гэсэн онцлог чанар, үлгэр жишээч байдлаараа ялгардаг. Энэ нь бид нэг нэгнээсээ суралцах соёлыг тогтоох нэг хаалга нь болдог юм.

Дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ

Бага ярьж, их хийе. Ийм соёлд бага багаар суралцаж байгаа. Бас захирагч, дарга нарын хэлсэн санал, санаачилгыг ажил, үүрэг гэж ойлгодог байя. Түүнийгээ хэрэгжүүлбэ. Тэгвэл бид бусдаас маш олон зүйлийг суралцана гэж боддог юм. Бас ахмадуудын үгийг сонсох хэрэгтэй. Тэд өөрсдийнхөө гаргасан алдааг биднээр давуулахыг хүсдэггүй. Тэтгэвэр, чөлөөнд гарсан дарга нараас түүх, сургамжийг нь сонсьё. Мөн багаар ажиллах чадвар хамгийн чухал. Хүн ганцаараа юунд ч хүрч чадахгүй. Амжилтыг минь хуваалцах хэн нэгэн үргэлж байдаг.

-ҮБХИС-д ажиллахдаа "Давах цаг" илтгэх урлаг, мэтгэлцээний клубийг үүсгэн байгуулсан. Үйл ажиллагаа нь одоо нэлээд зүгширч, жигдэрсэн. Сургуулийн зүгээс ч их дэмжлэг үзүүлдэг гэдгийг хэлэх нь зөв байх. Тус клубээр дамжуулан хувь хүний хөгжил рүү чиглэсэн сургалтыг явуулж, илтгэх урлаг болон

байсан учраас одоо санаанд буух юм бараг байхгүй. Миний хувьд цэргийн сургуульд элсэх нь олон талын боломж олгоно гэж бодсон учраас тэр. Цэргийн эрдэмд боловсрох, бас эр хүнийхээ хувьд төлөвших, өндөр хариуцлага, сахилга баттай байх чанарт суралцах гээд их зүйлийг төлөвлөөд байлаа. Гэхдээ үүнээс илүүтэй

Хүн төрөлхтний хамгийн алдартай 10 зэвсэг

Дэлхийн цэрэг, дайны түүх нь өөрөө хүн төрөлхтний хөгжлийн цаг үетэй салшгүй холбоотой байдаг.

Томоохон дайн, тулаан бүрийн цаана тухайн цаг үеийн инженерчлэл, хими, биологийн ололт амжилт

байсаар ирсэн юм. Ингээд энэ удаа дэлхийн түүхэнд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн, гүйцэтгэж байгаа

болон тухайн цаг үедээ шинэ технологи болж байсан 10 зэвсгийг танилцуулъя.

СӨРГӨӨ



Сөргөө гэж нэрлэдэг тус зэвсэг нь дөрвөн үзүүртэй бөгөөд аль ч талаараа газарт унасан нэг үзүүр нь дээш хардаг онцлогтой. Үүнийг олон зуун жилийн өмнөөс төдийгүй саяхныг болтол хэрэглэсэн иржээ. Сөргөөг МЭӨ 1331 онд Гаугамелийн тулаанд анх хэрэглэсэн тухай түүхийн сударт бичиж үлдээсэн байна. Тодруулбал Македионы Александр Месопатамийн эзэнт гүрэн (одоогийн Ирак улс)-ий Мосулын ойролцоох Гаугамелийн хөндийд Персийн III Дарий хааны армийн эсрэг хэрэглэжээ. Дараа нь Ромын эзэнт гүрний легионерууд ч хэрэглэж байсан түүх бий.

Улмаар энэ зэвсэг нь Чингис хааны цэргүүд Алтан улс руу довтолсон үеэс эхлэн олон зууны турш монголчуудын үндсэн зэвсэглэлийн нэг байсаар ирсэн. Дараа нь Орос, Төв Ази даяар сөргөөг өргөн хэрэглэх болж морин цэргийн эсрэг хэрэглэдэг гол зэвсэг болсоор XX зуунтай золгожээ. Тодруулбал, Дэлхийн нэгдүгээр дайны үед британичууд дайсны морин цэргийн эсрэг хэрэглэж байсан бөгөөд хамгийн сүүлд Вьетнамын дайны үед вьетнамчууд дайсны явган цэргийн эсрэг шугуйд ашигласан түүхэн баримт байдаг ажээ.

МИНА

1277 онд Хятадын Мин улсын үед цэргүүд газарт тэсрэх бөмбөг булж хэрэглэсэн нь түүхэнд мина хэрэглэсэн хамгийн анхны тохиолдол болжээ. Түүнээс хойш явган цэргийн мина



нь тасралтгүй хөгжсөөр үүрэг, зориулалт, төрлөөрөө ч олон янз болсон. Эдүгээ мина нь дан ганц явган цэргийн эсрэг бус танк, бусад бүх төрлийн хуягт тээвэрлэгч, автомашин эсэргүүцэх, агаараас эсэргүүцэх, усан онгоц, шумбагчаас эсэргүүцэх зэргээр маш олон төрлийн зориулалтаар хөгжсөн байна.

Дэлхийн нэг, хоёрдугаар дайнд газрын мина нь явган цэргийн эсрэг хамгийн үр ашигтай зэвсэг болж хувирсан төдийгүй өнөөдөр ч дэлхийн олон улсад газарт булаастай хэдэн мянгаар тоологдох газрын мина байдаг бөгөөд жил бүр дунджаар 18000-20000 хүн тус зэвсгийн уршгаас амь насаа алддаг гэсэн судалгааг олон улсын Газрын минийг хориглох байгууллагаас гаргажээ.

РАДАР

Орчин үеийн цэрэг, дайны хөгжилд радар маш чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Хамгийн анх 1940 онд англичууд радарыг хэрэглэсэн бөгөөд эрдэмтэн, физикч



Роберт Уатсоныг "радарын эцэг" гэж хүлээн зөвшөөрдөг. Улмаар ЗХУ, Герман, Франц, АНУ тэргүүтэй улсууд хамгийн түрүүнд зэвсэглэлд нэвтрүүлэх ёстой эд гэдгийг нь маш сайн ухамсарласнаар англичууд радарын нууцаа гадаадын тагнуулуудад алдсан гэдэг.

Одоо үед радаргүйгээр ямар ч цэрэг, дайны ажиллагааг төсөөлөх боломжгүй нь ойлгомжтой. Ялангуяа тив алгасах, хормын дотор хөнөөлт цохилт өгөх пуужингууд олон орны зэвсэглэлд "ярайж" байгаа тул өндөр хүчин чадал бүхий радарын төхөөрөмжүүд нь тухайн улс орны үндэсний аюулгүй байдлын гол технологи болжээ.

ХИМИ, БИОЛОГИЙН ЗЭВСЭГ

Анх Бат хааны цэргүүд зүүн Европыг дайлах аян дайндаа буслагдсан хотын салхины дээд талаас нь үхсэн

хүн, малын сэгийг шатааж, дайсныхаа бие сэтгэлд хүчтэй хохирол учруулдаг байсан нь өдгөөгийн биологийн зэвсгийн эхлэл байжээ. Үүнээс хойш Алтан ордны хаан Жани Бэк 1346 онд жинхэнэ утгаар нь энэ төрлийн зэвсгийг ашигласан байдаг. Жани Бек хаан Крымын хойгийг уулгалан довтолж Каффа цайзыг удаан хугацаанд бүсэлжээ. Улмаар хотын



иргэд бууж өгөлгүй удаан хугацаанд эсэргүүцсэнээс Алтан ордны цэргүүд ч нэлээд их хохирол амссан байна. Гэвч монголчууд үхсэн хүний цогцсыг өмхийрүүлж, улмаар харвагч зэвсгээр хотын хэрмийг давуулан ихээр шидэж эхэлжээ. Ингэснээр хотод тахал дэгдэж Жани Бэкийг эсэргүүцэх ямар ч чадваргүй болж бууж өгсөн гэдэг.

Дараа нь Дэлхийн нэгдүгээр дайны үед хими, биологийн хорт хийг ихээр ашиглаж цэргүүд аймшигт үхлээр хэдэн мянгаараа нас барсан юм. Улмаар Дэлхийн хоёрдугаар дайны үед ч бактериологийн зэвсгийн хөгжил хурдацтай явагдаж, томоохон улсууд энэ төрлийн зэвсгийн судалгааг эрчимтэй явуулах болжээ. Үүнийг олон улсын Женевийн конвенцоор 1939 оноос эсэргүүцэж, 1972 онд Олон улсын хими, биологийн эсрэг конвенцыг соёрхон баталж, дэлхийн 180 гаруй улс энэхүү конвенцод нэгдэн оржээ.

ТОРПЕДО

Усан доогуур харвах пуужин торпедог анх 1866 онд



Австрийн эрдэмтэн Роберт Вайтхид шумбагч онгоцны эсрэг зохион бүтээсэн ажээ. Түүнээс хойш томоохон байлдаанд ашиглагдахгүй байсаар Дэлхийн нэгдүгээр дайнаас өмнө Орос Туркийн эсрэг байлдах үеэр Хар тэнгист анх хэрэглэжээ. Үүнээс хойш Дэлхийн нэг, хоёрдугаар дайны далай, тэнгист хийсэн тулаануудын гол зэвсэг болтлоо хөгжсөн билээ.

Британи болон бусад орнуудын далай, тэнгис дэх нөлөөллийн гол зэвсэг нь хүчирхэг торпедоор зэвсэглэсэн шумбагчууд байсан билээ. Одоо ямар ч улс орнуудын усан цэргийн зэвсэглэлийг торпедо пуужингүйгээр төсөөлөхийн аргагүй. Байлдааны хөлөг онгоц болон шумбагч онгоцны гол дайсан бол мэдээж хэрэг торпедо байсаар ирсэн ба одоо ч энэ хэвээр байна.

ГРАНАТ

Хамгийн анх манай эриний 960-1270 онд оршин тогтнож байсан Хятадын Сүн улс гранатыг хэрэглэж туршсан бөгөөд мөн л газрын минийн адил монголчууд дэлхий дахинд түгээсэн байдаг.



Сүн улсын цэргийн зүтгэлтэн Жэнь Титан Лэй анх дарийг шаварт ороон хүхэрт дүрсэн утастай холбосон нь эдүгээ орчин үеийн гранатын эхлэл байжээ. Түүнээс хойш дэлхийн олон улс гранатыг төрөл бүрийн зориулалтаар, олон хувилбараар бүтээж байна. Сүүлийн үед давшилтын болон хориглолтын гранатууд нь улам хөнгөн жинтэй болж, авч явахад илүү аюулгүй байдлаар зохион бүтээгдэж эхлээд байна.

ДУРАН ХАРААГ БУУНД ХЭРЭГЛЭСЭН НЬ

XIX зууны үеэс дайсныхаа удирдагч, дарга, офицерыг алсын зайнаас тусгайлан хөнөөх зэвсгийг боловсронгуй болгон хөгжүүлж байсан улс нь Их Британи юм. 1853 онд Английн Сир Жосеф Витфорд өндөр цэцтэй, хол тусгалтай винтов буур зохион бүтээж, Крымын дайны үеэр дуран хараа суулгасан нь мэргэн буудагчийн винтовын эхлэл байлаа.

Улмаар Дэлхийн нэгдүгээр дайны үед Германы мэргэн буучдын фронт дээрх хамгийн үр дүнтэй, дайсандаа хөнөөлтэй зэвсэг болон хувирч байлаа. Дэлхийн дайнаас хойш мэргэн бучийн дуран хараатай буу нь эдүгээ хүртэл хөлсний алуурчдын гол зэвсэг болсон бөгөөд зэвсэглэлд чухал байр суурийг эзэлсэн хэвээр байна.



ТАНК

Хүн төрөлхтний сүүлийн 100 жилийн цэрэг, дайны түүхийг танкгүйгээр төсөөлөхийн аргагүй.

1904 онд өөрөө явагч хуягт машиныг Австри улсад зохион бүтээжээ. Уг машиныг цэргийн дарга, өндөр зэрэглэлтэй улс төрчдийн амь насыг хамгаалах зориулалтаар үйлдвэрлэж эхэлсэн байна. Үүний дараа Английн эрдэмтэд танкийг зохион бүтээх ажилд идэвхтэй оролцож 1916 онд анхны хуягт танкийг хөдөлгөсөн байна. Соммын тулалдааны үеэр Их Британий арми Уинстон Черчиллийн шууд удирдлаган дор 2600 орчим танкийг үйлдвэрлээд байсан нь тухайн цаг үедээ дэлхийн хамгийн хүчирхэг хуурай замын армийг үүсгээд байв. Дэлхийн нэгдүгээр дайны үед британичууд окопны байлдааны гацаанаас гарахын тулд танкийг анх бүтээж, байлдаанд хэрэглэжээ. Тухайн үед Герман Улс нь армидаа танкгүй байсан учир Английн инженерүүдийг хөлсөлж А-7V нэртэй



танкийг зэвсэглэлдээ нэвтрүүлсэн ч Дэлхийн нэгдүгээр дайны төгсгөл үе тохиож уг танкны байлдах чадвар төдийлөн туршигдаагүй юм. Америк, Итали зэрэг орнууд Британи, Францаас их хэмжээний танкийг худалдан авч байв. Харин оросууд тусдаа бие даан танкийг зохион бүтээх ажлыг өрнүүлж "Вездеход", "Небденко" нэртэй хоёр танкны төрлийг үйлдвэрлэх болжээ.

Энэ цагаас эхлэн дэлхийн бүх гүрнүүд танктай болохоор эрмэлзэж танк нь Дэлхийн хоёрдугаар дайны гол зэвсэг болсон юм. Энэ үеэр ЗХУ-ын Т-34 танк дэлхийн энх тайвныг аварсан билээ.

ИХ БУУ

Цэрэг, дайны зэвсэглэлд нэвтэрсэн технологийн шинэчлэлийг их бууггүйгээр төсөөлөхийн аргагүй. Дайны бурхан хэмээгдэх их бууг хамгийн анх хэрэглэсэн тохиолдол 1132 онд Хятадын Сүн улс Фучиан хотыг бүслэн эзлэх үеэр хэмээн түүхэнд тэмдэглэгдэжээ. Улмаар Монголчууд байлдан дагуулсныхаа үед баруун зүгт хийсэн аян дайндаа их бууг ашигласан байдаг. Улмаар их буу нь жинхэнэ хэв төрхөндөө орлоо хөгжиж явсаар дундад зууны үеэс дэлхийн тэргүүлэгч армиудын гол зэвсэг болж хувирчээ. Ийнхүү ялалт хэний талд вэ гэдгийг шийдвэрлэх гол хүчин их буунаас шалтгаалах болсоор эдүгээ хөгжлийнхөө оргилд хүрээд байна.

Сүүлийн жишээг дурдахад, Америкийн Тэнгисийн цэргийнхэн 160 километр хүртэлх зайд байрлах байг устгах чадвартай дэлхийн хамгийн хүчирхэг их бууг туршсан байна. Энэхүү цахилгаан соронзон их буу 9 килограмм жинтэй сумыг агаарт дууны хурдаас 7 дахин их хурдаар буудах чадвартай



юм. Virginia мужийн Dahlgren дахь Тэнгисийн цэргийн хүчний төвд бүтээсэн төхөөрөмжийн тусламжтайгаар туршилтын их бууны гол төмөрт 33 Мегажоул хүч үүсгэж чадсан нь дэлхийн рекордыг тогтоожээ. Энэ нь 2008 онд тогтоосон өмнөх дээд амжилтаас 3 дахин их үзүүлэлт юм. Нэг мегажоул хүч нь нэг тонн жинтэй автомашиныг 160 километр зайд тээвэрлэх хүчтэй тэнцдэг байна.

Нүүрийг бэлтгэсэн ахмад М.МӨНХЗОРИГ

ДУРСАМЖ ДҮҮРЭН ШИНЭ ЖИЛ

Гудамж талбай гэрлээр цацарч, өнгө үзэмжээ нэмэн нэгэн оныг үдэж, шинэ оноо угтаж байгаа энэ цаг жилийн хамгийн гэгээлэг үе гэлтэй. Нэг жилийн хийсэн ажлаа дүгнэж, ирэх жил, ирээдүйд хийх бүхнээ төлөвлөн байдаг бөгөөд хүн бүрийн дурсамжид хадгалагдан байдаг шинэ жилийн баяртай холбоотой дурсамж сэргэж буй гэдэгт итгэлтэй байна. Бид энэ удаагийнхаа дугаарын зочноор Зэвсэгт хүчний Жанжин штабын Материал техникийн газрын Зэвсгийн хэлтсийн дарга, хурандаа П.ЧИНЗОРИГИЙГ урьж сэтгэлд нь хадгалагдан байдаг дурсамж дүүрэн шинэ жилийнх нь талаар болон өнгөрч буй оны ажил, алба, бүтээл дагуулсан бүхнийх нь талаар хөөрөлдлөө.



болж өнгөрсөн бэ?

-Манай хэлтсийн хувьд 2020 он их бүтээлийн жил болж өнгөрлөө. Зөвхөн тооллогын ажлаар гэхэд Монгол Улсаа бүтэн тойрсон байна. Тодруулбал, 11.000 км явж шалган туслах ажлыг хийсэн. Мөн мэргэжлийн шинэ ангитай болохын зэрэгцээ "Зэвсэглэлд сайжруулалт хийх арга зам-2020" онол практикийн хурлыг зохион байгуулсан. Батлан хамгаалах яам болон Зэвсэгт хүчний Жанжин штабын удирдлага, Зэвсгийн мэргэжилтнүүдийн холбоо бусад газар, хэлтэс их ач холбогдол өгсөн. Хийх шаардлагатай, тулгамдаж буй асуудлыг хөндсөн чухал ажил болж үр дүнгээ өгсөн мэтгэлцээнийг тухайн үед өрнүүлсэн. Мөн Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн О.Сэрдарийн мэндэлсний 100 жилийн ойд зориулан "Зэвсгийн мастер-2020" мэргэжлийн аварга шалгаруулах тэмцээнийг хоёр дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. "Буудлагын зэвсгийн сайжруулалт", "Агсамж" төслийг Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулсан гээд дурдвал хийж бүтээсэн ажлууд их байгаа. Тийм ч учраас Ар талын газраас намайг ЗХЖШ-ын "2020 оны шилдэг удирдах албан тушаалтан" номинацад нэр дэвшүүлсэн байх.

Ирэх оны таны төлөвлөгөө ...

-Төлөвлөсөн зүйл их байна. Манайхны хэлдгээр "под" цүнхийг

Хэрхэн цэргийн хүн болсон талаараа дурсана уу?

-Би Улаанбаатар хотын унаган хүүхэд. "Сансар"-т байрладаг нийслэлийн Ерөнхий боловсролын 33 дугаар дунд сургуулийн сахилгагүйчүүдийн тоонд ордог, хөдөлгөөнтэй хүү байсан. Тэр хэрээрээ багш нарын зөвлөгөөнөөр орно. Тэр үед "Ирээдүйн одод", "Сарны дуу" гэх зэрэг дууны тэмцээнд орж тухайн үедээ л "од" явсан. 10 дугаар ангиа төгсөөд "8 дахь гараг" чөлөөт цагийн төвд дуучин гэх тодотголтой үсээ ургуулаад, чихээ цоолчихсон тухайн үеийн "панк" залуу байлаа. Тэгсэн нэг удаа унтаад сэрсэн чинь аав маань үс хайчилчихсан, чихний ээмэг авчихсан байсан.

байсан. Залуу хүнийг хайрласан эцэг хүний халамж байсан гэж боддог.

Одоо манай зарим ангийн захирагч нар "Энэ хүнийг шилжүүлээд өгөөч" гэдэг. Муу хүн байхгүй, тэр хүнийг амьдралд сургаж төлөвшүүлэх нь ангийн удирдлагын бас нэг үүрэг байх ёстой.

-Цэргийн сургууль бол мэдлэг олгож төгсгөдөг. Түүнийгээ амьдралд баталгаажуулах нь хувь хүний үүрэг, амьдралд сургах нь ангийн удирдлага, хамт олны үүрэг байх ёстой санагддаг. Миний хувьд залуусыг загнах, шүүмжлэхдээ биш урамшуулах өөрөөрөө үлгэрлэх гэж хичээдэг. Манай рэнжер, хурандаа Б.Түвшинбаяр хувцастайгаа

П.Чинзориг: МОНГОЛ ӨВЛИЙН ӨВГӨН КАЗАХСТАН ЦАСАН ОХИН, ГҮРЖ ҮНЭГТЭЙГЭЭ УКРАИН ШУЛАМСАД ХӨӨГДӨӨД ...

Энэ замаар явбал бүтэхгүй хүн гарч ирнэ гэж бодсон бололтой. "Цэргийн сургуульд бүртгүүлчихсэн. Тэнд орж хүн бол, эр хүн бол, эх орондоо хэрэгтэй иргэн болж суралц" хэмээн үүрэг болгосон. Өөрийн сонирхлоор биш аавынхаа хүслээр цэргийн сургуульд орсон.

Ямархан сонсогч байсан бэ?

-Цэргийн сургуульд бас л хөдөлгөөнтэй сонсогч нарын тоонд ордог байсан. Манай оныхон ч мэдэх байх. Ямар сайндаа 3 дугаар курсээ төгсөх жилдээ сахилгын арга хэмжээ авахуулж зэвсгийн нярваар ажлын гараагаа эхэлсэн юм. Одоо бодоход зэвсгийн нярваас зэвсгийн хэлтсийн дарга болтлоо ажилласан нь ховор тохиолдол. Залуучуудад хэлэхэд, хүн нэг алдахдаа амьдрал дууссан юм шиг битгий гунигла, ирээдүйд үргэлж боломж байдаг юм. Тэгээд нэг жилийн дараа ирж шалгалтаа өгөөд хүсэн хүлээсэн дэслэгч цолоо авч байлаа.

Шинээн дэслэгчийн ажлын гараа хаанаас эхэлж байв ...

-Миний өнөөг хүртэл хүндэтгэж явдаг олноо "Буурал Түмээ" гэж алдаршсан хурандаа Л.Түмэнжаргалын ангид хуваарилагдсан. Захирагчаасаа маш их айдаг бас хүндэлдэг байлаа. Тэр үед захирагч маань "Энэ залуучуудын гарт цалинг нь битгий бүтнээр нь өг, 30 хувийг л өг. Доргиод мөнгөө үрээд дуусгана. Үлдсэнийг нь кассад хадгал" гээд үүрэг өгчихсэн. Мань мэт тухайн үедээ их дургүйцдэг байсан боловч энэ нь ямар их тустай, амьдралд хэрэгтэй шийдвэр байсныг нь хожим мэдсэн. Яагаад гэвэл, амралтаараа явахад хадгалсан мөнгөө бөөнд нь аваад харьдаг

мөлхөөд л заадаг даа. Хэчнээн бахдам харагддаг билээ.

Хамгийн их дурсамж дүүрэн шинэ жилээ нэрлээч гэвэл ...

-Миний хувьд шинэ жилийн баяр бүр онцлог байдаг. Ер нь дурсамжууд маш их байдаг ч сэтгэлд тодхон үлдсэн дурсамжуудаасаа хуваалцъя. 2014 онд Туркийн Зэвсэгт хүчний Дайны академид суралцаж байх үед нэг өдөр хаалга тогшоод "улс улсын төлөөлөл болсон офицеруудын гэргий нар тантай уулзаж гэсэн юм" гэж байна. Яваад очтол тэд нар "Удахгүй шинэ жил болно. Исламын улсууд шинэ жилд нэг их ач холбогдол өгдөггүй юм аа. Цөмөрөө хүүхдүүдээ байрлуулаад бас гэр бүлээрээ хөгжилдөж өнгөрөөө" гэсэн санал тавьдаг юм байна. Би ч "За би ёстой чадахгүй юм байна. Та нарын итгэлийг алдана уучлаарай" гэж хэлээд гэр лүүгээ орсон. Тэгсэн аавууд гээд 10 гаруй орны залуус нийлчихсэн дуудаад "Та бид нар дундаас хамгийн том цолтой, мөн насаар ахмад, тэгээд ч их нүүрэмгий учраас чадна" гээд нуман тулгуурт оруулчихлаа. Тэгээд турк, орос, англи хэлээр мэндчилгээний үг унших баахан даалгавартай гэртээ орлоо. Охин хүртэл "Та хичээлээ боль, энэ дүрээ бэлд" гээд үүрэгдчихсэн, за миний нэр гарахгүй Монгол Улсын нэр гарч магадгүй гэж бодоод гурван хоног үгээ толинд харж уншаад, өрөөн дотроо алхаж их л хичээсэн санагддаг юм.

Тэгээд монгол өвлийн өвгөн маань казахстан цасан охинтой, Гүржийн үнэгээ дагуулаад Украин шуламсад хөөгдөөд шинэ жилийн танхимд ортол хүүхдүүд маш их баярлаж байсан. Цасан охин, амьтад нь офицеруудын эхнэрүүд байсан бөгөөд хүүхдүүдээ хэлэлгүй бэлтгэлээ хийж, гэнэтийн бэлэг барьж байгаа нь энэ. Ингэж 30 гаруй орны гэр бүл, найз нөхөд нийлсэн нижгэр танхимд яваад орлоо, үгээ ч хэллээ, бэлгээ ч тараалаа. Хамгийн хэцүү нь сандал дээр суугаад зураг даруулах. Бас л бэрх ажил байна лээ шүү. Халууцаад хөлс гараад л бараг 2 цаг "фон" болсон. Нөгөө шинэ жил тодоогүй гивлүүртэй хүүхнүүд, Африкийн орныхон хүртэл ирж зургаа даруулсан даа.

Мөн ханьтайгаа Зэвсэгт хүчний Жанжин штабын шинэ жилийн баярын цэнгүүнд орох бүрдээ азын сугалааны эзэн болдог. Баярын цэнгүүний хүрээнд зохион байгуулсан "Яг түүн шиг" дууны уралдаанд "Харанга"-ын Лхагвасүрэнг дуурайж түрүүлсэн зэрэг дурсамжтай үйл явдлууд шинэ жилээр тохиож байж дээ.

Танай гэр бүл шинэ жилийн баярын өдрийг хэрхэн угтаж, өнгөрүүлдэг вэ?

-Дээр хэлсэнчлэн манай гэр бүлийнхний хамгаас дуртай, хүлээдэг баяр бол шинэ жилийн баяр. 11 дүгээр сар гаргаад л "болк" яригдаж эхэлнэ. Манай эхнэр хүүхдүүдээрээ дамжуулан гацуур модоо засъя гэж гуйлгана.

Дэлгүүр хэсэж байхдаа хүртэл тоглоом, шинэ жилийн чимэглэл аваад нэмээд байдаг юм. Эмэгтэй хүн нэг бодлын хүүхдүүдээсээ илүү бүхий л баярт ач холбогдол өгдөг юм шиг санагддаг. Энэ нь баяр цэнгэлд дуртайдаа бус гэр бүлийнхээ уур амьсгалыг халуун дулаан болгох гэж зорьдог гэлтэй. Оны сүүлчийн өдөр гэр бүлээрээ салат, буузаа хийж идээд он солигдохыг хүлээх нь жил бүр давтагддаг ч цаанаа л сэтгэл догдуулдаг торгон агшин. Манай эхнэр хүүхдийн шампанск хүртэл авчихдаг. Тэгээд буудуулцаана даа. Гадаад ч байсан интернэтээр шампанскаа тулгаж гэр бүлийнхээ хайрыг мэдэрдэг юм.

Энэ баярт хүн бүр дуртай байдаг шалтгааныг та юу гэж боддог вэ?

-Хүн ер нь шинэ зүйлд их дуртай байдаг. Шинээр төрсөн хүүхэд, шинэ хувцас, шинэ байр, шинэ машин гэх мэт. Түүн шиг шинэ жилийг шинэ сайхан бүх зүйлийн эхлэл гэж бэлгэдэж, муу бүхэн ард үлдэх болтугай гэж ерөөдөг учраас энэ баярт их ач холбогдол өгдөг байх. Энэ нь монгол ёс заншилтай ч холбоотой. Сар шинийн баяраар шинэ дээлээ өмсөж, идээ будаагаа засаж цайныхаа дээжийг өргөдөг шиг шинэ жилийн баяр орчин үеийн хувилбар нь болсон байх.

Нэг он солигдож хүн бүр хуучин ондоо хийж бүтээсэн ажлаа дүгнэж байна. Таны хувьд өнгөрч буй 2020 он хэр үр бүтээлтэй, ажил ундарсан жил

зэвсэглэлийн эд хэрэглэлээс хасаж, цэргийн алба хаагч бүрийг нэг стандартын, нэг загварын, чанартай агсамжтай болгож, Зэвсэгт хүчнээс хангалтаар өгдөг болгох. Мөн автоматын сайжруулалтаа үргэлжлүүлэн цаашдаа бүх зэвсэглэлдээ нэмэгдэл тоног хэрэгсэл угсрах ажлыг эхлүүлэх, буудлагын зэвсгийн нэр томьёоны нэгдсэн стандарттай болгох зэрэг олон шинэ ажилг хэрэгсэл ажил бидний өмнө байна.

Сүүлчийн асуултыг танд үлдээе ...

-Дэлхий даяар тархаад байгаа цар тахалд төгсгөл ирж бүх сайхан зүйлийн эхлэл 2021 онд тавигдана гэдэгт итгэлтэй байна. Монгол Улсын эдийн засаг сэргэж, Зэвсэгт хүчинд шинэчлэл үргэлжлэн, шинэ дэвшилтэт технологийг суурилсан зэвсгэлэл техниктэй, оюун ухаан, инновац, шинжлэх ухааны шинэ эрин эхлэх үүд хаалга нээгдэнэ гэж бодож, итгэж, өрөөж байна.

Бидэнд бие бялдар, оюун санааны асар их боломж байгаа нь дэлхийд үнэлэгдэж зарим улс монгол дайчдаар бахархдаг. Цаашдаа зэвсэглэл, техникийн хөгжилд анхаарлаа хандуулах цаг нэгэнт иржээ гэж бодож байна. Монгол Улсын Зэвсэгт хүчин мөнхөд мандан бадрах болтугай. "Соёмбо" сонины уншигч танд шинэ жилийн баярын мэнд дэвшүүлж эрүүл энх, аз жаргал бүхнийг хүсье.

Хошууч Д.ОЮУНГЭРЭЛ

OSPRING ЦАЙРТАЙ ШҮҮЛЛЭГ УС. КОРОНАВИРУСЫН ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗӨВЛӨМЖ. ХАНИАЛГАХ, НАЙТААЛГАХДАА ИХ АЖЛАХ ДЭМЖ, АМНЫ ХААЛТ ХЭРЭГЛЭХ. ОЛОН НИЙТИЙН ГАЗАР ШААХДАГСҮЙ БЭЛ ЗӨРЧИЛҮЙ БАЙЖ АМНЫ ХААЛТ ТОГТМОЛ ХЭРЭГЛЭХ. ГАРАА ТОГТМОЛ САВАНДАЖ УГААХ. ХАНИАДНЫ ШИНЖ ТЭМДЭГ ИЛЭРСЭН БОЛ ЗӨЧД ТАНДАХ. МАЛ ЗЭРЛЭГ АМЬТНААС ХӨН БАЙХ. ЭРДЭСТЭЙ УС ТОГТМОЛ ХЭРЭГЛЭХ.

Үндэсний бахархал, ОБ СОЁЛ ОЛОЛТТОЙ БҮТЭЭЛ. Цэргийн авто засварын слесарь Даваажав нь богино хугацааны дотор найман тооны машиныг бүрнээ засварлаж дуусгасны дээр бусад хэд хэдэн тооны машинуудад жижиг засваруудыг хийж зохих ажилд хэрэглэхэд ямар ч саадгүй бэлхэн болгосон баймуй. Энэ нь ноогдсон үүргээ гавшгайгаар гүйцэтгэж буй баримт мөн. Манай авто техникийн мэргэжилтэн бүхэн нь нөхөр Даваажавын сайн үлгэрийг авч үүргээ идэвхтэйгээр гүйцэтгэж, Ардын Хувьсгалт Цэргийн байлдах хүч чадлыг шинэ шатнаа өргөж гаргах хэрэгт чадвартайгаар оролцон, идэвхтэйгээр гүйцэтгэлцэхийг уриалмуй. Цэрэндорж. Батлан хамгаалахын төв архивын сан хөмрөгөөс "Улаан-Одон" сонин. 1941.01.01. Дугаар 1.

СОЁМБО СОНИН. "Соёмбо" сонин 96 дахь жилдээ хэвлэгдэж байна. Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА, Д.НАЦАГДОРЖ.

Эрхлэгч Хурандаа Батжаргалын ОТГОНБАЯР. Эхийг "Соёмбо" сонины редакцияд бэлтгэж, "Соёмбо принтинг" хэвлэх үйлдвэрт хэвлүүлэв.

*Зар, рекламьг хямд нийтэлнэ. *Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна. *Зохиогчийн үзэл бодол сонины нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно. *Тус сонины мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс 10018. И-мэйл хаяг: Mil_newssoyombo@yahoo.com Утас: 70001029

ТЛАНАЙД ӨНЖЬЕ



"ХҮН БОЛЖ ТӨРӨӨД АМЬД ЯВНА ГЭДЭГ ХАМГИЙН ТОМ ЭРХ АШИГ. ГЭТЭЛ ҮҮНЭЭС ДАВСАН ЭРХ АШИГ НЬ ЭХ ОРНЫХОО ТӨЛӨӨ ЗҮТГЭХ ЮМ ..."

хатуужил, тэсвэр тэвчээрийг нь мөн алдагдуулалгүйгээр яг л алх дөшинд давтсан офицеруудыг бий болгох нь түүний мөрөөдөл аж.

Түүний цэргийн эрдэмд, аливаад судалгаатай, ул суурьтай ханддаг байдал нь олон эх сурвалжаас мэдлэг, мэдээллээ баталгаажуулдагтай нь холбоотой. Тийм ч учраас эх сурвалжаа үргэлж хоёр хэлээр уншиж баталгаажуулдаг байсан нь чамлалттай санагдахдаа гурав дахь хэл сурах шаардлага

сурах хэрэгтэй хэмээн зөвлөхийн зэрэгцээ хамгийн сүүлд уншсан "Томоор мөрөөд" номыг манлайлагч болох, тэргүүнд явах хүсэл сонирхолтой залуусыг уншаарай гэж захисан юм.

ГЕНЕРАЛ МӨЛХҮҮЛДЭГ ХЭН БЭ?

Гол баатрын маань ханийг Т.Амаржаргал гэдэг бөгөөд тэд оюутан ахуйн "шиг"-үүд аж. Ханилан суугаад 30 гаруй жилийг хамт элээж байгаа хоёр маань өдгөө охин, хүү,

аавынхаа ном унших зуршлыг яг өвчсөн нэгэн байдаг гэнэ. ОХУ-д сургуулиа төгсөөд ирэхдээ ачаа нь багтахгүй байхад нь хувцас хунараа шатааж орхиод, бүх номуудаа авчраад ээждээ эмлүүлж байсан удаатай. Мөн Хятад улсад аяллаар явж байхдаа, гэр бүлээрээ гадуур гарах болоход аав, охин хоёр номын дэлгүүр явах сонирхолтой. Ээж, хүү хоёр дэлгүүр хэсэх сонирхолтой байснаар хоёр хуваагдаад явж байсан аж. Гол баатрын маань хувьд хамгийн

Цас бударсан амралтын өдөр зорин очсон айл маань Монгол Улсын Зэвсэгт хүчний отгон генерал Ч.Цогтжаргалынх байлаа. Өнгөрсөн 10 дугаар сард тохисон Монгол Улсад генерал цол бий болсны 76 жилийн ойн өдрөөр гурван хүн мөрдэс дээрээ цэргийн дээд цолыг гялалзуулсны нэг нь Чимэдгочоогийн Цогтжаргал юм.

Тэр бээр хуучнаар Сайн ноён хан аймгийн Баатар бэйсийн хошууны хүү юм. Сургуулийн захирал, багш аав, эмч ээжтэй тэрээр айлын ууган хүү бөгөөд хичээл зааж буй аавыгаа, өвчинд шаналсан олныг эмчилдэг ээжийгээ харж өөрөө гавьяа байгуулсан дайтай баярлахын зэрэгцээ энэ хэрээрээ ээж, ааваараа бахархан төрсөн нутаг Идэрийн голынхоо усанд шумбаж хүүхэд ахуй цагаа өнгөрөөжээ.

МИНИЙ АМЬСГАЛАХ АГААР БОЛ ЗЭВСЭГТ ХҮЧИН

10 дугаар ангиа төгсдөг жилээ мэргэжил сонгох талаар хэд хэдэн сонголт байсан хэдий ч цэргийн хүн болохоор шийдсэн ажээ. Учир нь гурван жил цэргийн алба хаагаад ирсэн, цэргийн дүрэмт хувцсаар ижилдэн гоёсон нутгийн ах нарын цэгцэрсэн бие, жавхаатай байдал, хүнтэй харьцах харилцаа, хандлага зэрэг нь тухайн үед түүнд гүнзгий сэтгэгдлийг төрүүлснээр цэргийн хүн болох сонголтоо хийжээ. Ээжийнхээ эсэргүүцэлтэй тулан байж хийсэн сонголт нь эхэндээ түүнд хүндхэн, халшрам даваа байсныг тэрээр нуугаагүй. Учир нь цэргийн сургуульд орсон даруйдаа "карантин"-д гарсан нь дээд сургуульд орсон бус цэргийн албанд ирсэн мэт санагдаж. Шувуу шиг эрх чөлөөтэй байсан түүнд унтах, босох, идэх, сурах гээд бүхий зүйл нарийн хуваарийн дагуу үргэлжлэх бөгөөд энэ хязгаарлагдмал байдал нь дасан зохицоход хүндхэн байж. Хожим бодоход энэ л үед дасан зохицож, тэсэж үлдсэн нь цэргийн хүн болох эхний бөгөөд хамгийн чухал даваа нь байсан гэдэг.

Сонсогчоос эхлээд бага даргаар дамжин өөрийн биеэр бүхий л зүйлсэд суралцаж эхэлсэн энэ үеэс л эх орон гэдэг чинь маш ариун нандин, үүнийхээ төлөө зүтгэнэ гэдэг аминаас үнэтэй зүйл юм гэдгийг ухаарчээ. "Хүн болж төрөөд амьд явна гэдэг хамгийн том эрх ашиг гэж боддог. Гэтэл үүнээс давсан эрх ашиг нь эх орныхоо төлөө зүтгэх байдаг. Үүнийг цэргийн бид мөн бидний гэр бүл л мэдэрдэг болов уу" гэж тэрээр хэлсэн юм.

АРМИА ӨӨРЧЛӨӨД ӨГБЕ

Түүний ажлын анхны гараа Зэвсэгт хүчний 016 дугаар нөгтгөл байлаа. Хуваарилагдан очоод нэг их удаагүй байхад нь тус дивиз татан буугдахтай зэрэгцэн ардчиллын салхи сэвэлзэв. Бүхнийг өөрчлөх, шинэчлэх суртал ухуулга ихээр явж байсан тухайн цаг үед тэрээр "Армийг өөрчлөөд өгье" гэсэн санаачилгыг өрнүүлэн хэсэг нөхдийн хамт ухуулга хуудас бэлдэж Зүүнбаян руу явах хүсэлтээ өгч байсан түүх бий. Нийгмийн сэтгэхүйгээ дагаад бид өр нь л арга барилаа өөрчлөх хэрэгтэй, арай өөрөөр сэтгэх хэрэгтэй, алсыг харах хэрэгтэй гэсэн ойлголтоо тухайн

Цогтжаргал: ХУВЬ ЗАЯАНААС БУРХАН ХҮРТЭЛ АЙДАГ

үед олж авсан бөгөөд энэ л ухагдахуунаа өнөө хэр сэтгэлдээ тээн алхам тутамдаа хэрэгжүүлж явахыг эрхэм болгож ирсэн нэгэн юм.

Түүний дараагийн томилолт нь дөнгөж шинээр байгуулагдаж байсан элитийн батальон буюу Зэвсэгт хүчний 150 дугаар анги байлаа. Мэргэжлийн цэргийн анги байгуулах түүхэн цаг үед тулгын чулууг нь тавилцсан тэрээр тухайн үед сургалт хариуцсан офицер байв. Бүхий л зүйл нь шинэ болохоор анхны сургалтыг зохион байгуулахад тухайн үед багагүй хүндэрл гарч байжээ. Тухайлбал, түүний хувьд өмнөх ангиудад ажиллаж байсан аргачлалаар буюу хугацаат цэргийн алба хаагчидтай явуулж байсан сургалтаа явуулах гэсэн чамлагдаад байв. Цэргийн нэгдсэн дээд сургуулийн төлөвлөгөөгөөр явах гэсэн мөн л таарч өгөхгүй байж. Ингээд сургалтаа төлөвлөж чадахгүй байсан хүн аав дээрээ очиж зөвлөгөө хүсэхэд багагүй зүйлийг хэлж өгснөөр мэргэжлийн анхны ангийн захирагч нь Цэрэнчимэд хурандаа байсан бөгөөд тэрээр тухайн залуу үеийн офицеруудад ихийг зааж, чиглүүлж өгсөн гавьяатай нэгэн. Мөн Чимээ хурандаа бол хойч үеэ бэлдэх, шинийг санаачлах, төлөвлөгөө боловсруулах зэрэгт залуучуудад мундаг үлгэр дуурайлал болсон цэргийн дарга хэмээн байнга баярлаж явдаг гэдгээ энэ үеэр хэллээ. Учир нь түүний эрдмийн ажил хийх, бичиг цаастай зууралдах дуртай болсон нь Чимээ хурандаагаас эхтэй бөгөөд ямар нэгэн ажлыг эхэлж чадахгүй бол зүгээр л барьж аваад бичиж эхэл, санаандаа орсон бүгдээ бич, тэгж байхад голдиролдоо орно гэдгийг анх хэлж байсан бөгөөд үүнийг өдий хэр нь хэрэгжүүлсээр байгаа аж.

АХИСАН ТҮВШНИЙ МЭДЛЭГИЙГ НОМООС АВЧ ЧАДНА

Хойч үеэ бэлдэх, дараа үеэ хэрхэн гаргаж ирэх талаар энэ үеийн дарга болсон бид бүхэн тухайн үеийн мундаг дарга нараас чамлалттай санагддаг бөгөөд тиймдээ ч одоо хэр нь суралцаар, судалсаар, боловсорч байдгаа энэ дашрамд дурдсан юм. Мөн түүний ажил, амьдралын нэгээхэн хэсэг нь ҮБХИС-тай холбоотой бөгөөд 14 жилийг тухайн сургуульд суралцаж, шат дараалсан албан тушаалуудад томилогдон үүрэг гүйцэтгэж байсан юм. Боловсролд тулгуурласан цэргийн сургалт гэдэг бол түүний баримталдаг зарчим хэдий ч

тулгарсан гэдэг. Учир нь тэрээр барууны цэргийн боловсролд нэвтрэх, судлах, мэдлэгийн хүрээгээ тэлэх үүднээс англи хэлийг 48 настайдаа сурч эхэлсэн байна. Сурахад нас хамаагүй ч хурд удааширдаг юм билээ гэх хэдий ч тэрээр англи хэлээ чамгүй сайн сурч НАТО-ийн цэргийн академид суралцаж чадсан байна. Үүгээрээ тэрээр барууны цэргийн номлол юу байв, орос дээр тулгуурласан бидний стратеги, тактикаас юу нь өөр байв гэдгийг өөрийнхөө

хүргэн, бэр, ач, зээ гээд ам бүл наймуулаа болж өнөр өтгөн айлын эгнээнд орсон.

Цэргийн хүний ар талыг авч явах хүндхэн бөгөөд хариуцлагатай алба тун сайн авч явсны илрэл нь ханийнх нь хашиж буй албан тушаал, цол бэлхнээ илтгэн харуулна. Өдрийн цагаар ажлаа хийж, шөнийн цагаар ном бичих, эрдмийн ажлуудад нь ч тусалж "Pentium-4" компьютер дээр бичээчийн хийж байсан түүх тэдэнд бий. Анх ханилан суухдаа

их баярласан үе нь хэзээ юм бол хэмээн асуухад анх аав болохдоо урд хожид мэдрэгдэж байгаагүй их баяр баясал мэдэрч байсан бол өвөө болоод мөн л тэр мэдрэмжээ ахин авч магнай нь тэнийж байсан гэнэ. Өвөө болгосон зээ охин нь гурван настай, бол ач охин нь тун удахгүй нэг ой хүрэх аж. Өвөөгийн амь зээ охин нь Эрдэнэт хотод амьдардаг бөгөөд хотод ирэхээрээ өвөөгийн "энгэрийн зүүлт" болдог гэнэ. Ач охины хувьд хамт амьдарч байгаа бөгөөд генерал дагуулаад



хэмжээнд судалж чадсан гэдэг. Хүн сурч боловсрох хэрэгтэй, сурсан бүхнээ ажил амьдралдаа хэрэгжүүлэх хэрэгтэй, өөрийн хүлээсэн үүрэг, эрхэлсэн ажлаа сайн хийх ёстой гэсэн бидний үеийн зарчим сүүлийн үед бага зэрэг өөрчлөгдөж өндөр албан тушаалтай хүнтэй ойр байж, шат дамжихгүй дээгүүр ажил хийх сонирхолтой залуус гарч ирж байгаад сэтгэл дундуур явдгаа ч мөн энэ үеэр хэлж байсан.

Мөн залууст хандан, сонголт их болсон өнөө үед ахисан түвшний мэдлэгийг авахын тулд өөрт чинь, ажил, албан тушаалд чинь хэрэг болох номыг сонгож мэдлэгийн хүрээгээ тэлэхийг уриалж байсан. Зав чөлөө, боломж гарахаар уншина гэж хойш тавих, боломжийг хүлээх бус хэрэгтэй цаг, боломжийг өөртөө бүрдүүлж

бүхий л зүйл дээр өөр өөр байр суурьтай байсан бол өдгөө тэд нэг хэвэнд цутгасан аятай хоёр биедээ эзэнгшин дасжээ.

Цэргийн хүний хань болсондоо баярлах үе миний амьдралд бишгүйдээ л байсан. Жишээлбэл, олон сайхан орноор явж, аялж байлаа. Мөн хамгийн чухал нь охин, хүү хоёроо хамгийн сайнаар өсгөн хүмүүжүүлэхийн зэрэгцээ нэг нь Орос, нэг нь Япон улсад боловсрол эзэмшүүлж, эх орондоо иргэн хүнийхээ үүргийг хүлээж байна. Залуу байхад бид хоёр хүүхдийн хүмүүжлийн талаар их л зөрчилддөг байсан юм. Миний бодлоор хүүхдүүдээ их зөөлөн хандаад байсан. Гэтэл одоо харахад зөөлөн ч хатуу зарчимтай байж, хүүхдүүдээ хүний дээдээр хүмүүжүүлсэн байна гэж боддог талаараа хэлж байсан.

Том охины хувьд

мөлхөх бүрэн эрх тэр жижиг "атаманд" л байна даа хэмээн инээмсэглэн ярьж байсан. Гэр бүлээ хэрхэн, яаж авч явах, үр хүүхдээ хэрхэн хүмүүжүүлэх вэ гэдэг бол аав хүний нийгмийн өмнө хүлээсэн чухал үүрэг. Харин ажил үүргээ нэр төртэй, мадаггүй биелүүлэх нь эх орныхоо өмнө хүлээсэн цэргийн бидний аминаас үнэтэй үүрэг гэж боддог. Түүнчлэн хүүхэд байхдаа цэргийн хүн болбол гоё харагдана гэж сэтгэлийн хөөрлөөр бодож явсан нь одоо миний амьсгалах агаар бол Зэвсэгт хүчин юм гэж хэлсэн нь хэчнээн бардам, хэчнээн бахархам гэлтэй. Мөн тэрээр ярилцлагынхаа төгсгөлд "Хүн ямар ч замыг туулсан хувь заяагаараа явж байгаа гэдэгт би итгэдэг. Энэ хувь заяа гэдэг зүйлээс бурхан хүртэл айдаг" юм гэв.

Хошууч Д.ОЮУНГЭРЭЛ

ОНЦЛОХ ЭРХЭМ

Нэгэн зууны босгыг давах гэж байгаа Зэвсэгт хүчний түүхэнд тод мөр үлдсэн баяжиж буй хуудас нь яахын аргагүй энхийг сахиулах ажиллагаа юм. Эдүгээ 18 жилийн хугацаанд давхардсан тоогоор 18000 гаруй энхийг сахиулагч үүргээ нэр төртэй гүйцэтгэжээ. Тэдний дундаас энэ түүхэнд өөрийн тод мөрөө үлдээж яваа эрхэм хурандааг "Редакцын уулзалт" буландаа урьж оролцууллаа. Тэр бол Зэвсэгт хүчний Агаарын цэргийн штабын дарга, хурандаа Б.ЭРДЭНЭБАТ юм.

Б.Эрдэнэбат: ЖАНЖИН ШТАБЫН ДАРГА ТЭР ҮЕД НАДАД “ЧИ ДАРГА БИЗ ДЭЭ” Л ГЭЖ ХЭЛСЭН



Цаашдаа энхийг сахиулах ажиллагаанд Зэвсэгт хүчний оролцоо ямар байх вэ, энэ тухай ярилцлагаа эхэлье?

—Монгол Улсын Зэвсэгт хүчний энхийг сахиулах үйлсийн эхлэлийг тавьсан хүн нь ЗХЖШ-ын орлогч дарга, Энхийг сахиулах ажиллагааны газрын анхны дарга, хошууч генерал Г.Рагчаа гэдгийг бид мэднэ. Гэхдээ хошууч генерал Р.Гаваа агсны бичсэн номыг уншиж байхад тэр бээр АНУ-ын Ази-Номхон далайн командлалын албаны хүмүүстэй 1990 онд уулзах үеэрээ энэ асуудлаар ярилцаж, Монгол Улсын Зэвсэгт хүчний байр суурийг илэрхийлж байсан удаатай юм билээ. Ингээд хууль, эрх зүйн орчин бүрдсээр 2002 онд анх хурандаа Р.Даваадорж, Ч.Ерөөлцэнгэл нар Бүгд Найрамдах Ардчилсан Конго Ард Улсад НҮБ-ын "MONUSCO" ажиллагаанд ажиглагчаар үүрэг гүйцэтгэсэн. Тэднийг явахад Монгол Улсын Ерөнхийлөгч хүлээн авч, уулзсан байдаг. Эндээс анх удаа хилийн чанадад үүрэг гүйцэтгэсэн цэргүүдээ төр, засаг ямар их ач холбогдол өгч, хүндэтгэж байсныг нь харж болно. Харин цэргийн баг оролцсон анхны ажиллагаа бол 2003 онд явагдсан "Иракийн эрх чөлөө" ажиллагаа бөгөөд мотобуудлагын ротыг барилга-инженерийн салаатайгаар илгээж байлаа. Үүнээс цааш Афганистан, Чад, Сьерра Леон, Судан, Өмнөд Судан улсад монгол цэрэг хөл тавьж, үүрэг гүйцэтгэсэн. Хэдийгээр бидний зэвсэглэл, техник НАТО-ийн орнуудын цэргүүдтэй харьцуулахад сайн биш ч сахилга, зохион байгуулалт, мэргэжлийн үүрэг гүйцэтгэлтэйгээрээ бусдаас илүү гэдгээ дэлхийд харуулж чадсан. Нөгөө талаар өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд удирдлагын түвшинд үүрэг гүйцэтгэх чадвартай бүрэлдэхүүн бэлтгэгдэжээ. Тиймээс цаашдаа НҮБ-ын цэргийн ажиллагаанд удирдах бүрэлдэхүүнийг түлхүү оролцуулах боломж бидэнд бүрдсэн гэсэн үг. Үүнд сектор командлагчаас дээш хүчний командлагч хүртэлх албан тушаалууд, мөн НҮБ-ын Нью-Йорк хот дахь төв штабт хүмүүсээ түлхүү оролцоо болгожтой. Дараагийн алхам бол хилийн чанадад тусгай хүчний, барилга-инженерийн болон бусад тусгай мэргэжлийн цэргийг оролцуулах явдал юм.

Анхны ажиллагаандаа явж байснаас эхлээд "UNMISS" ажиллагааны секторын штабын даргаар үүрэг гүйцэтгэх хүртэлх хугацаанд та хэдэн удаа энхийг сахиулсан бэ?

—Ирак, Сьерра Леон, Косово, БНӨСУ-д тус тус энхийг сахиулжээ. "Иракийн эрх чөлөө" ажиллагааны хоёрдугаар ээлжээр бид олон улсын "Чарли" баазын хамгаалалтыг харуулдаг байсан. Мэдээж Ойрх Дорнод, Африк тив хоёрын цагийн байдлыг харьцуулахад маш өөр. Ойрх Дорнодод олон үндэстний цэргүүдийн эсрэг хэрэглэдэг зэвсэг, арга техник нь маш боловсронгуй бөгөөд энэ утгаараа аюулын зэрэг ч маш өндөр. Харин БНӨСУ-д 2008-2009 онд цэргийн ажиглагч, 2013-2014 онд батальоны захирагчаар үүрэг гүйцэтгэсэн. Тэр үед батальон гурван өөр газар Паранг, Румбек, Вауд ротуудаа тараан байрлуулсан байв. Энэ нь цагийн байдал хүндэрсэн үед ротуудаа нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахад бэрхшээл учруулж байлаа. Харин "UNMISS" ажиллагааны Өмнөд секторын штабын даргаар үүрэг гүйцэтгэхэд олон улсын түвшинд хүмүүсийг удирдаж, асуудлыг илүү том зургаар харж ажилласан. Миний даргаар нь ажилласан штаб нь хүний нөөц, ар тал, ажиллагаа, холбоо зэрэг хэлтэстэй бөгөөд 30 гаруй хүн үүрэг гүйцэтгэдэг байсан. Олон улсын цэргүүдийг удирдлагаар хангаж ажиллахад миний өмнө

оролцож, сурч байсан олон улсын сургалт, дамжаанууд маш хэрэг болсон. Мөн миний төгссөн АНУ-ын Агаарын цэргийн хүчний Команд штабын коллеж, Дайны коллеж зэрэг нь удирдлагын түвшинд шийдвэр гаргах, стратегийн түвшинд асуудлыг харахад тус болсон.

Таныг "UNMISS" ажиллагаанд цагийн байдлын хүнд нөхцөлд үүрэг гүйцэтгэснийг мэднэ. Энэ тухайгаа дурсан ярина уу?

—2013-2014 онд "UNMISS" ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байхад Өмнөд Судан улсад зөвхөн Засгийн газрын болон Засгийн газрын эсрэг хүчин л гэж байсан бол дөрвөн жилийн дараа секторын штабын даргаар эргээд очиход Засгийн газрын эсрэг хүчний маш олон бүлэглэл, намууд бий болчихсон, цагийн байдал нь улам ээдрээтэй болсон байв. Намайг цэргийн багийн захирагчаар очиход цагийн байдал маш тогтворгүй болсон нь ойлгомжтой байсан. Биднийг 2013 оны 12 дугаар сарын 19-ний орой Бентьюд очиход НҮБ-ын мужийн зохицуулагчаас эхлээд бусад хүмүүс надад хандан "Удахгүй НҮБ-ын бааз руу орон гэрээсээ дүрвэсэн 2000 гаруй хүн орж ирнэ. Энэ үед монгол цэрэг яаж үүрэг гүйцэтгэх вэ?" гэж асуусан. Тэр үед би энэ асуудлыг цэргийн багийн нийт бүрэлдэхүүнд хэлээгүй. Цэргүүдээ сэтгэл зүйн хувьд тайван байлгах гэж тэр шүү дээ. Ингээд орой 21.00 цаг болоход баазын ойролцоо хэдэн зуугаараа буудалцаад эхэлсэн. Тэр үед Бентьюгээс НҮБ-ын энгийн ажилчдыг бааз руу татан гаргалтаар авчрах ажиллагааг манай цэргийн баг зохион байгуулсан. Бид шөнөжин НҮБ-ын шархадсан ажилчдад өөрсдийн эмнэлгийн ороо, боох материалаараа тусламж үзүүлж байлаа. Тэр үед Жулбад НҮБ-ын штабт холбооны даргаар үүрэг гүйцэтгэж байсан дэд хурандаа Э.Болор надтай холбоонд орохдоо өөрийн байрлаж байгаа баазад өрнөж байгаа цагийн байдлын талаар хэлсэн. Тодруулбал, цагийн байдал хүндэрч 30 гаруй мянган дүрвэгч баазад ороод ирчихсэн, эмх замбараагүй байдал үүсэж аюулгүй байдал алдагдлаа гэсэн. Тэгтэл удалгүй Бентьюд НҮБ-ын албаны хүмүүс хуралдаж, олноороо ирж байгаа хүмүүсийг баазад байрлуулах талаар ярьж эхлэв ээ. Би ч авсан мэдээлэлдээ тулгуурлан энэ асуудлыг хэзээ ч хүлээн зөвшөөрөхгүй гэдгээ илэрхийлэхэд НҮБ-ын ажилчид дүрвэгсдийн хүний эрх зөрчигдөнө, баазад нэвтрүүлэх нь зүйтэй гэх мэтээр ярьж байлаа. Харин би "Тэгвэл ямар нэгэн юм болж, дүрвэгчид та нар руу дайрвал аюулгүй байдлыг чинь бид нар хариуцахгүй шүү" гэж хэлсэн. Ингэж бааз руу дүрвэгч оруулах асуудлыг шийдвэрлэсэн нь цагийн байдлыг хүндэрч, цэргүүдээ болон бусад хүмүүсийг элдэв эрсдэлд орохоос сэргийлж чадсан.

Энэ үед мөн миний хэрэгжүүлсэн нэг зүйл нь холбоо давхцуулахгүй байхад анхаарсан явдал юм. Ингэхийн тулд өөрөө баазын хамгийн өндөр цэгт гараад бүх холбоог хүлээлгийн горимд шилжүүлж, батальоноо удирдлагаар хангадаг байсан. Иракт болсон бидний гашуун туршлага бий. Харуулын цэг дээр байсан алба хаагч халдлага болоход сандарсандаа "Харрис" станцын тангентийг нам атгачихсан. Түүнээс болж бааз даяараа ямар ч холбоогүй болсон.

Тун сонирхолтой түүх байна. Мөн танай цэргүүд нефть ачиж явсан усан онгоцыг хамгаалж байхдаа халдлагад өртсөн тохиолдол байдаг ...

—Малакалд байсан Энэтхэгийн батальон манайхаас завь жолоодох хүн байна уу гэж асуусан. Би тэгэхэд нь манайд тэнгисийн цэрэг байхгүй, чадахгүй гэхэд танайд хийлдэг завь байгаа түүнийгээ хүмүүстэйгээ өгөөч

гэсэн юм. Учир нь нефть ачааг том усан онгоц нь эрэгт ойртолгүй завиар хүмүүсээ зөөж эрэг рүү гаргадаг онцлогтой юм билээ. Тэр үүргийг манайхан гүйцэтгэхээр болсон хэрэг. Жубагаас Малакал хүртэл 750 км газар Нил мөрний урсгал сөрж 19 хоног тус усан онгоц явсан. Батальоны зүгээс дөрвөн залууг энэ ажиллагаанд томилсон. Гэтэл асуудал явсан гэхээр анх Жубагаас уг онгоцыг хөдлөхөд нь Энэтхэгийн цэргүүд хамгаалж байхдаа Бор хэмээх газарт бужигнаанд оролцож байсан орон нутгийн хэдэн цэрэг хувцастай нөхдийг буудаад унагаачихаж. Үүнээсээ болж цаашид үүсэх нөхцөл байдлаас зугтааж, хамгаалалтаа Непалийн цэргүүд рүү шилжүүлж өгсөн байгаа юм. Ингээд хүнээ алдсан босогчид удалгүй Малакал орчимд усан онгоцыг ирэхэд нь отолт хийсэн. Энэ үед ахлах ахлагч Ц.Төрбаатар над руу сансрын холбоогоор ярихад цаана нь буун дуу тачигнах чимээ тод сонсогдож, байдал нэлээд хүнд байгаа нь мэдэгдсэн. Халдлага нь сүүлдээ автомат, гранатомёт болоод явчихсан. Тэр үед гранатомётын сумны хэлтэрхийнд манай нэг цэргийн алба хаагч шархадсан. Бидний зүгээс нисдэг тэргээр татан гаргалт хийлгэхээр 12.00 цагт хүсэлт явуулахад НҮБ-ын олон дарга нараар дамжин хугацаа алдсаар маргааш нь зөвшөөрөл гарч нисдэг тэргэ очсон. Хэрвээ цэргүүд хүнд шархадсан бол тэндээ маш хүнд байдал орох байлаа. Мөн отолт болсон газраас холгүй Малакал дээр Энэтхэгийн батальон байрлаж байсан ч тэд отгон ч хөдлөөгүй.

Цагийн байдал хүндэрсэн үед Танд хамгийн түрүүнд ямар бодол төрдөг вэ?

—Тийм үед энэ олон аавын хүүхдүүдийг эсэн мэнд эх оронд нь авч очих юм сан л гэж бодно. Ер нь Цэргийн багийн захиргагч хүн бүтэн нойртой хоноход тун хэцүү. Гэхдээ цагийн байдал өөрчлөгдөж, хүндрэхэд цэргүүд илүү сахилга баттай болдог. Мөн нэгэн тохиолдлыг нэмж хэлэхэд, баазын хойно 20 гаруй километр байрлах нефтийн үйлдвэрт Орос, Кени, Этиопийн иргэд халдлагад өртөөд хүнд байдалд орсон. Хүчний командлагч "Чи эдгээр хүмүүсийн амь насыг аварч чадах уу?" гэхэд нь би бээр "Хэрвээ та үүрэг болговол чадна" гэсэн. Ингээд хоёр хуягт тээвэрлэгчтэй бүлэг томилоод буудалцаан болж байгаа газар руу илгээн тэдгээр хүмүүсийг татан гаргаж, эмнэлэгт хүргэж өгсөн. Энэ явдлыг Угандад байдаг ОХУ-ын Элчин сайдын яамнаас сайшааж, ажиллагаанд баярлалаа гэдгээ албан ёсоор илэрхийлснээр "UNMISS"-ын нэр хүнд өндөрт өргөгдсөн. Гэтэл бид оронтойгоо анх удаа мэдэж билээ. Тэгээд эх орон руугаа буцахдаа "МИАТ"-ын онгоцонд суугаад үхрийн хэрчсэн мах идээд хөлс гоожиж, эх орондоо газардаад сэнгэнэсэн агаараар нь амьсгалах ямар сайхан байдгийг ч мэдэрсэн. Дараа нь "Иракийн эрх чөлөө" ажиллагаанд очоод дайны хөлд нэрвэгдсэн хүмүүсийг хараад, Өмнөд Суданд амьдарч

байгаа хүмүүс, тэдний орчин, нөхцөлийг нь хараад бид чинь ямар сайхан, аугаа эх оронтой юм бэ гэж өөрийн эрхгүй бодсон. Энэ бодол бол ажиллагаанд явсан хүн бүрд төрдөг. Гэхдээ заримдаа хөгжингүй Америк, Канад зэрэг улсаар явж байхад эх орон минь хаана нь яваад байна даа гэсэн бодол ч төрнө. Гэвч хөгжил гэдэг нь дан ганц байшин барилгаар хэмжигдэхгүй, хувь хүний ёс зүй, ёс суртахуун энд том байр эзэлнэ гэж боддог.

Та цагийн байдал хүндэрсэн тэр үед өөрийгөө хэрхэн зоригжуулсан бэ?

—Цагийн байдал хүндэрсэн талаар тэр үед ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Ц.Бямбажавт илтгэл өгсөн. Тэгэхэд "жанжин" дарга надад ганцхан богино өгүүлбэр л хэлсэн. Тэр нь "Чи дарга биз дээ" гэж. Тэр үг намайг их зүйлийг бодоход хүргэсэн. Мөн нэгэн урам зориг авсан зүйл нь бригадын генерал Д.Баярсайханы надад явуулсан мэйл байлаа. Тэр үед Баярсайхан дарга БНӨСУ-ын Секторын командлагчаар явах гэдэг цагийн байдлыг судалж байсан. Тэр хүн мөн Иракийн хоёрдугаар ээлжээр манай цэргийн багийн захирагчаар явсныг та бүхэн мэднэ. Д.Баярсайхан генерал захидлынхаа эхэнд "Эрхэм дүүгийн амрыг эрье ..." гэсэн байсан. Би уул нь цэрэг нь шүү дээ, гэтэл надад хандаж тэгж бичсэн нь их дотно сэтгэлийг төрүүлсэн. Тэр бээр цааш нь би наана чинь болж байгаа цагийн байдлыг нэлээд ажиглалаа гээд надад тулгарч болох эрсдэлүүдийн талаар бичсэн. Ингээд төгсгөлд нь "... Би Иракт байхдаа нэг баазыг л хамгаалж байсан. Гэтэл чиний хувьд ротууд чинь тус тусдаа байрлалчихсан, цагийн байдал тун ээдрээтэй, энэ үед батальоныг удирдлагаар хангахад хүндрэл гарна. Гэхдээ эрхэм дүү алзахгүй гэдэгт найдаж байна" гэсэн байлаа. Яг нуулгүй хэлэхэд, би тэр захиаг ганцаараа уншаад сэтгэл маш их хөдөлж, нулимс дусааж байсан. Цэргийн багийн захирагчийн зовлонг ганцхан Цэргийн багийн захирагч л ойлгоно гэдэг үг бий. Магадгүй Баярсайхан даргад 2004 онд тохиолдож байсан хүнд үе миний нөхцөл байдалтай тухайн үед таарч байсан биз. Тэр захидал надад сэтгэлийн их дэм өгсөн.

Энэ бүхний дараа та хэр их магтаал хүртсэн бэ?

—Магтаал гээд байх зүйл авч байгаагүй. Тэгээд ч ямар нэгэн магтаал сайшаалын төлөө би тэнд томилогдоогүй. Энд нэг зүйл хэлэхэд би тухайн үед зарим ангийн захирагч нарт үнэхээр гомдсон. Заах аргын цугларалт дээр хошууч генерал Ж.Бадамбазараас зөвшөөрөл авч, ангийн захирагч нарт хандан залуусаа амраагаарай, тэд хэдэн зуу, мянгаар нь үхсэн хүнийг харсаар ирсэн шүү. Маш хүнд нөхцөлд үүрэг гүйцэтгэсэн шүү гэхэд зарим ангийн захирагч нар залуусыг маань шууд маргааш нь л ажилд нь оруулсан байсан.

Ярилцлагын төгсгөлийн асуултыг танд үлдээе.

—Бид энхийг сахиулах ажиллагаанд оролцож байгаа энэ 20 жилийн хугацаанд тийм ч дардан замаар энэхүү нэр хүндийг олж аваагүй. Тодорхой хэмжээгээр цэргийн алба хаагчид маань эрсдэлд орж байсан. Тиймээс яг 2002-2022 онд хийсэн, алдсан, оносон бүхнээ багцлаад нэг мөр болгосон гарт баригдахаар ямар нэгэн зүйл хийж болжээ. Энэ нь зургийн цомог, ном, эсвэл сэтгүүл хэлбэрээр ч байж болох юм. Ямар ч байсан монгол цэргийг хилийн чанадад очиж үүрэг гүйцэтгэсэн 20 жилийн түүхээ бид баримт болгон авч үлдэх ёстой гэж бодож байна.

Ахмад М.МӨНХЗОРИГ

ЭРДЭМТНИЙ ЦАГ

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Нүдний тасгийн зөвлөх эмч А.Буяндэлгэртэй ярилцлаа. Тэрээр өөрийн нүүр номоороо дамжуулан чихрийн шижин өвчин, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөөг хүргэдэг юм.

Бид мэдлэг нимгэн, ойлголт бүрдэж байдаг тул өвчнөө хүндрүүлчихдэг дутагдалтай. Эхлээд чихрийн шижин гэж ямар өвчин байдаг талаарх ойлголтыг уншигчдад хүргэе.

-Юуны өмнө миний үзэл баримтлал, ойлголт өнөөдрийн Монголын хэмжээнд мөрдөгдөж байгаа эмчилгээний стандартаас зөрдөг гэдгийг хэлье. Монголд энэ талын ойлголт хараахан нийтэд түгээмэл болж чадаагүй юм. Ерөнхийдөө хүлээж авах үйл явц удаан байна.

Манай эмнэлэг АНУ-ын эмч, доктор Бернштейнийн чихрийн шижингийн нүдний хүндрэлээс урьдчилан сэргийлэх аргыг нэвтрүүлээд хоёр жил болж байна. АНУ-даа сахарын өвчтэй нийт хүмүүсийн 10 хувьд нь нэвтрээд 50 гаруй жил нутагшсан. Мэдээж хэрэг анагаах ухааны нотолгоонд суурилсан. Чихрийн шижин өвчний нэг болон хоёрдугаар хэлбэр гэж байдаг. Тус өвчнөөр өвдсөн хүн амын 80-90 хувь нь хоёр, 10-20 хувь нь нэгдүгээр хэлбэрийнх гэж тэмдэглэгдэнэ. Хоёрдугаар хэлбэр хүндэрсэн тохиолдолд цусан дахь сахарын хэмжээ ихэсдэг. Харин нэгдүгээр хэлбэр нь эхэн үедээ цусан дахь сахарын хэмжээ нь ихэсдэг. Үүгээрээ төсөөтэй гэж хэлж болно. Бага насны хүүхэд, залуучууд нэгдүгээр хэлбэрээр өвчлөх нь элбэг. Нойр булчирхай хангалттай хэмжээний инсулин боловсруулж чадахгүй эсвэл боловсорсон инсулин нь биеийн эсүүдэд нөлөөлж чадахгүй болсон үед чихрийн шижин өвчин үүсдэг. Өөрөөр хэлбэл, инсулинийн шүүрэл багасах болон инсулинийн дааврын үйлдэл алдагдсанаас цусны глюкозын хэмжээ ихэсдэг. Үүний улмаас цусан дахь сахарын хэмжээг зохицуулдаг инсулин нэртэй дааврыг ялгаруулахаа больдог. Бидний өдөр тутамдаа хэрэглэж байгаа хүнсний зүйл цусанд сахар болж ордог. Гэтэл энэ сахарыг цааш нь эд эсүүдэд хүргэж өгөх нь инсулинийн үүрэг.

Эндээс тодорхой шинж тэмдгүүд илэрдэг байх нь ...

-Үр дагаварт нь их уух, их шээх гэх мэт хам шинжээр илэрдэг бодисын солилцооны эмгэг бий болдог. Нэгдүгээр хэлбэрийн чихрийн шижинтэй үед дээрх шинж тэмдэг илэрнэ. Цаашлаад амархан ядарч сульдана, биеийн хөгжил зогсох гээд нэрлээд байвал олон. Хоёрдугаар хэлбэрийг инсулинийн харьцангуй дутагдлын үе гэнэ. Инсулинийн ялгаралт хэвийн ч биеийн эсүүд түүнийг мэдрэхээ болихгүй хэлнэ. Ихэвчлэн 35-аас дээш насныхан энэ хэлбэрээр өвчилсөн байдаг. Мөн чихрийн шижин өвчтэй гэж оношлогдсон хүмүүсийн 90-95 хувьд нь хамааралтай.

Ер нь энэ өвчний талаар ярина гэвэл хүн төрөлхтний түүхээс эхлэх хэрэгтэй. Хүн сармагчнаас бий болж, галыг амьдрал ахуйдаа хэрэглэх болсон тэр цагаас бидний оюун ухаан үсрэнгүй хөгжсөн. Хүн 10,000 жилийн өмнөөс улаан буудай тариалж эхэлсэн. Харин сахар 100, химийн найрлагатай хүнсний бүтээгдэхүүн 50-70 гаруй жилийн өмнө үүссэн байдаг. Өөрөөр хэлбэл, хүний үүссэн он цагтай харьцуулахад энэ тоо хамаагүй бага гэдэг. Улаанбуудайнаас эхлээд хүний биеийн сахарын агууламжийг ихэсгэдэг бүтээгдэхүүнийг бид сая дурдлаа. Үүнээс өмнө хүн төрөлхтөн ихэвчлэн мах, өөхөөр л хооллодог байсан. Энэ үедээ ямар ч сахарын өвчлөлгүй болоод л байсан хэрэг.

Та шинжлэх ухаан хөгжөөгүй хүний нийгмийн анхны байгууллын үед одоогийнхоос илүү дээр байсан гэж хэлэх гээд байх шиг байна ...

-Энэ нь сахарын агууламжтай бүтээгдэхүүн

иддэггүй байсантай холбоотой. Гэтэл ХХ зуунтай золгогтоо монголчууд өөх, махаа л иддэг байсан шүү дээ. Тэр үеийн хүмүүсийг таргалалттай гэж хэлэхэд хэцүү. Цусан дахь сахарын хэмжээг нь авч үзвэл биднээс хавь эрүүл биетэй хүмүүс байсан гэж болно. Бүр энгийн жишээ авъя л даа. Чоно, гэрийн тэжээвэр нохой хоёроос ялгаа нь мэдрэгдэнэ.

шингээж чаддаг, 88 хувь нь чаддаггүй. Төрөлхийн гурил, чихрийн үл зохицолтой гэж хэлж болно. Тааруулж хэрэглэнэ гэж байхгүй. Гурилнаас зугтаах л зам бий. Монголын хүн амын 60 гаруй хувь нь илүү, түүний гуравны нэг нь хэт илүү жинтэй гэсэн судалгаа гарсан байна лээ. Хамгийн сүүлийн үеийнх биш ч гэлээ ойрмогхон хийсэн судалгаа. Хүний биед 5 грамм цэвэр сахар байдаг. Хоолны том аягаар цуйван идлээ гэхэд 100 грамм цэвэр сахар цусанд орж ирнэ. Ингээд нойр булчирхайнаас инсулинийн даавар огцом ялгарч сахрыг

бүх төрлийн чулуу, бамбайны дутагдал, дааврын илүүдэл, хортой хоргүй хавдар, үе мөчний өвчин үүснэ гээд явж өгнө. Цусны даралт, чихрийн шижин тэс ондоо өвчнүүд биш. Инсулинийн дөжрөлийн өөр өөр илрэлүүд гэсэн үг.

Нэг жишээ хэлье, цусны инсулинд өөрчлөлт бий болсноос үүдэж цусны даралт ихэссэн тохиолдолд яах вэ. Шалтгаангүй цусны даралт гэсэн онош тавина. Ингэснээр суурь өвчнийг нь эмчлэлгүй үлдээж байгаа юм. Нэг ёсондоо илэрсэн шинж тэмдгийг л дарж байгаа хэлбэр. Түүнээс биш

тулд өвчнийг сууриар нь дарахаар Бернштейн эмчийн арга барилыг дагаж байна. Хүндэрсэн үедээ ирсэн ч эдгэрэх боломжтой. Чихрийн шижин хоёрдугаар хэлбэртэй шилжсэн бол тасралтгүй даамжирдаг, эмчлэгдэх боломжгүй гэж тодорхойлсон байх нь бий л дээ. Гэхдээ ийм байдлаас ангижрах, гарах арга зам бий. Дээр дурдсан арга барилаар үүнийг хийх боломжтой. Түүнчлэн энэ жишгээс гажихгүй, эмчилгээг тууштай хэрэгжүүлбэл эрүүл мэндийн салбар нийт зардлаа 75 хувиар хэмнэх боломжтой гэсэн тооцооллыг Бернштейн

А.Буяндэлгэр: "БИ САХАРГҮЙ" ГЭДЭГ ХҮН ОЛОН БИЙ, ГЭВЧ ...



Чоно зөвхөн махаар хооллодог. Нохойдоо бид юу эсийг өгдөг билээ дээ.

Өөхний хэрэглээг тал талаас нь л тайлбарлацгаадаг. Ойлголт нэг талдаа гарч чадахгүй байгаагаас бид өөхийг хэрэглэх нь зөв, буруу гэдэг дээр одоог хүртэл эргэлздэг ...

-Өөх нь уургийн агууламж өндөртэй. Мөн хүний биед "А" хэлбэрийн бага нягтралтай липопротейнийг ихэсдэг. "А" хэлбэрийн бага нягтралтай липопротейн нь энергийн эх үүсвэр болдог гадна судасны хананд наалддаггүй. Өөх бидний дайсан гэдэг үзлээс салах хэрэгтэй. Олон арван жил гурил, төмс, будаа, чихрээр хооллосон хүмүүс өөх тостой хоолонд дастал заавал хугацаа шаардана. Гагцхүү өөрийнхөө биеийг эрүүл болох боломж олго.

Монголчууд бид хүүхдийг бор хоолонд ороогүй шахам байхад нь аманд нь сүүлний өөх үмхүүлчихдэг. Уг нь иймэрхүү уламжлалт арга барил таны хэлсэнтэй зөрөхгүй байна, тийм үү?

-Шинжлэх ухааны үндэслэлтэй гэж хэлж болно. Сүүлний өөх нь ханаагүй хүчил ихтэй. Мөн хүүхдийн дархлааг маш сайн дэмждэг. Бэлчээрийн малын гаралтай л бол асуудалгүй. Өлсөх мэдрэмж төрөх нь ч бага. Өөх хэрэггүй гэсэн үзэл бол бидний дайсан.

Үл зохицлын талаар мэдээлэл хүргэнэ үү?

-Гурил, чихэр, цагаан будаа, төмс, жимс гэх мэт цусан дахь сахарыг огцом ихэсгэдэг эдгээр хүнсний бүтээгдэхүүнийг нийт хүн амын 12 хувь нь

эд, эс рүү чинь хуваарилна. Нэг сар, нэг жил, бүр 10 жил ч шингэнэ. Тодорхой хугацааны дараа энэ их сахарыг шингээх, хадгалах боломжгүй болно. Энэ үед өнөөх илүүдэл сахар нь өөх болж хувирдаг. Таргалалт өнөөх гурил, будаа, төмс, жимс зэргийн хэрэглээнээс үүдэлтэй. Өөх цусан дахь сахарын хэмжээг ихэсгэлгүй тогтоон барьдаг. Өөрөөр хэлбэл, таргалаад өөхлөөд байгаа нь нэг талаараа бидний хамгаалж байгаа урвалын нэг хэлбэр юм. Харин дараа нь олон жилийн хойно өнөөх сахарыг өөх болгож хадгалдаг дааврын хэмжээ багасахаар турах үйл явц эхэлдэг. Үүнийг чихрийн шижингийн хоёрдугаар хэлбэр гэж нэрлэнэ. Яг үндэндээ хэзээ таргалж эхэлнэ, тэр үед өвчин үүснэ. Эрүүл хүн хэзээ ч таргалахгүй. Хүн таргалах үед чихрийн шижингийн хоёрдугаар хэлбэрийн суурь болдог гэсэн үг. Энэ механизмыг ойлговол эмчилгээгээ зөв хийж чадна.

Чихрийн шижингийн хоёрдугаар хэлбэрийг инсулинийн дөжрөлийн үетэй холбон тайлбарлаж болох юм. Гурил, чихэр их хэмжээгээр тогтмол олон жил хэрэглээнээс болж хүний биеийн эд эс рүү өөрийн инсулин нь орж чадахаа больж инсулинийн дөжрөл үүсдэг. Инсулинийн дөжрөлийн эхний шинж тэмдэг таргалалт, дараагийн шинж тэмдэг нь цусан дахь сахар ихсэх үзэгдэл юм. Мөн инсулинийн дөжрөлөөс болж цусны даралт ихсэхээс авахуулаад бусад өвчин үүсдэг. Бүр хүний биед үүсдэг нийт өвчний 70 хувь нь ч бий болох магадлал өндөр. Таргалалтаас цусны даралт, зүрхний шигдээс,

эх үүсвэрийг нь хөндөөгүй гэсэн үг. Хорт хавдрын тухайд авч үзье. Хавдрыг нь тайраад авлаа гэхэд эх үүсгүүр нь цусан дахь инсулинд байж л байна. Тиймээс Бернштейн эмчийн дэвшүүлж буй саналаар бодисын солилцооны хямрал, илрэлүүдийг сууриар нь эмчилье гэж байгаа юм.

Өвчний хор хөнөөлийн талаар юу гэж хэлэх вэ? Сэтгэл сэрдхийлгэм аймшигтай үр дүн гардаг юм билээ ...

-Чихрийн шижинг нийгмийн асуудал, нийгмийн өвчин гэж хүлээж авах хэрэгтэй. Ингэвэл илүү ач холбогдол өгнө. Өвчний хор хөнөөлийн тухайд эмчилгээ үр дүнд хүрэхгүй бол 5, 10 магадгүй 20 жилийн дараа гар, хөлөө тайруулаа, нүд сохрох, тархины үйл ажиллагаа буурч амархан зөнөх, мартамхай болох зэрэг аюул бий. Бүх эд эрхтэн, мэдрэлийн тогтолцоонд нөлөөлнө гэсэн үг. Чихрийн шижингийн хоёрдугаар хэлбэр нь ийм сөрөг үр дагавартай. Дээрээс нь жам ёсоороо хөгширнө гэсэн ойлголт байхгүй. Гэхдээ үүнийг эрүүлээр даван туулах боломжтой. Цаг алдахгүй байх нь гол. Эмчилгээний гурван зарчим бий.

Хэр үр дүнтэй вэ?

-Нэгд, өөх тос ихтэй, илчлэг сайтай хоол хүнснийг хэрэглэх, нүүрс ус багатай хоолны дэглэм сайн барих. Энэ нь эмчилгээний 90 хувь нь. Дараагийн дугаарт хүчний болон биеийн тамирын дасгал тогтмол хийх. Гуравт богинын мацгийг орлодог эм тариаг заавар, зөвлөмжийн дагуу хэрэглэ. Гол нь ингэж хэвших нь чухал. Бернштейн эмчийн гол баримталж буй зарчим энэ. Хэзээ гурил, жимс, чихэр иднэ, тэр үед хүний бие дэх сахрын агууламж өснө. Манай ихэнх эмч нүүрс усыг тааруулан хэрэглэх тухай зөвлөдөг. Бернштейн эмчийн онолоор нүүрс усны төрөлхийн үл зохицол гэж байдаг. Энэ талаар нийт хүн амын 88 хувь нь төрөлхийн үл зохицолтой гэж дээр дурдсан. Нөгөө онол нь хүний биед хоол хүнсээр дамжин орж байгаа илчлэг, зарцуулж байгаа энерги хоорондын зөрүүний талаар юм. Энэ хоёр хоорондоо зөрүүтэй байвал буюу илчлэг ихтэй хоол идээд, бага энерги зарцуулбал алсдаа чихрийн шижинтэй болно гэж үздэг.

Миний хувьд чихрийн шижин өвчний эсрэг эмчилгээг нэвтрүүлээд хоёр жил болж байна. Чихрийн шижин өвчин даамжирч харааны эрхтэнд нь сөрөг нөлөө үзүүлэх тохиолдол элбэг. Ийм тохиолдлоор өвчилсөн иргэд биднийг зориод ирэхэд зөвхөн нүдийг нь эмчилж, үлдсэнийг нь дотоод шүүрлийн булчирхайн эмч нарт даатгаад явуулдаг байсан. Харин одоо бид идэвхтэй оролцож харааны эрхтэнг хамгаалахын

эмч гаргасан. Түүний онолыг хамгийн анх хүлээн зөвшөөрсөн улс бол Швед бөгөөд 2014 онд тус улсын 800 гаруй хоолны эмч, дотрын эмч нартайгаа санал нэгдэж Засгийн газартаа Бернштейн эмчийн аргыг нэвтрүүлэе гэсэн албан бичиг хүргүүлсэн. Зургаан жилийн үр дүнд өвчлөлийн тоо нь 10 дахин буурсан.

Бид зөвхөн мах, өөхний хэрэглээнээс хамааралтай байхдаа эрүүл байсан тухай та ярьсан даа. Үүнтэй адил, төстэй жишээ байна уу?

-Нэг зүйлийг сонирхуулъя. 1913 онд Германы эмч нар Африкийн зарим улсад очиж судалгаа хийсэн байна. Гурил, чихэр, болон бусад сахарын агууламжийг ихэсгэдэг бүтээгдэхүүн очоогүй байсан үед юм гэнэ. Тухайн үед судалгаанд оролцсон иргэдийн шүд эрүүл, хоолойн махгүй, мухар олгой ургаагүй, хорт хавдаргүй, ямар ч таргалалтгүй, цусны өвчингүй байж. Үүнийгээ баримтжуулж, баталгаажуулаад буцсан байна. Харин 30 жилийн дараа Африкт очиход иргэдийнх нь дунд төрөл бүрийн өвчлөл бий болсон гэдгийг нь тэмдэглэсэн байна лээ. Өөрөөр хэлбэл, хүнсний хэрэглээнд нь шинэ бүтээгдэхүүнүүд нэвтэрсэн гэсэн үг. Бидний эмээ, өвөө, аав, ээж хүйтэн сэрүүнд өөх, тостой, илчлэг сайтай хоол, зундаа цагаан идээгээ хэрэглэдэг байсан. Өвчлөлөөс хол байсан гол шалтгаан нь энэ. Өнгөрсөн цэрэг татлагын дүнгээр л гэхэд, эрүүл шүдтэй хүний тоо хангалттай хэмжээнд хүрч чадаагүй шүү дээ. Өнөөдөр Монгол Улс ходоодны болон элэгний хорт хавдраар дэлхийд тэргүүлчихсэн явж байна. Иргэдийн маань гурил, цагаан будаа, чихрийн хэрэглээ хэт өндөр байна. Тиймээс өөхтэй мах ид гэж дахин зөвлөө. Хүнсний ногооноос байцайг оруулж болно.

Сүүлийн жилүүдэд энэ өвчнөөр өвдөх иргэдийн нас хэт залуужсан нь санаа зовоож байна ...

-Ой ч хүрээгүй хүүхдийг бантангаар хооллож байна. Борог хоолонд ороход нь мөн л гурил, төмс өгдөг. Цэцэрлэгт нь ч ялгаагүй. Тийм балчир бие энэ их нүүрс, усыг дийлэх үү, дийлэхгүй. Ер нь гурил, төмс, будаанд бидний биед шаардлагатай амин дэм юу ч байхгүй. Хэрэгтэй нүүрс усаа мах, шар будаа, гурвалжин будаа, байцайнаас авч болно. Монгол Улсад энэ өвчнөөр өвчилсөн нийт 30-аад мянган иргэн бий. Ганц, хоёр жилийн өмнө албан ёсоор бүртгэгдсэн тоо нь. Таргалалттай мөртлөө "би сахаргүй" гэдэг хүн олон. Гэвч аль хэдийнээ эхэлчихсэн байхыг үгүйсгэх аргагүй.

Ярилцсанд баярлалаа. Дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ

СОНИРХУУЛБЯ

ҮНДСЭН ХУУЛИЙН СОДОН ЗААЛТУУД



Үндсэн хууль бол төрийн байгууламжийг тодорхойлсон, хамгийн дээд шатны, суурь хууль юм. Үүгээр улс төр, эрх зүй, эдийн засгийн суурь тогтолцоог тодорхойлдог. Үндсэн хууль бол нийгмийн гэрээ, зөрчиж үл болох тогтолцооны акт. Үндсэн хуулиар эрх зүйн хэм хэмжээ, төрийн дээд байгууллагыг байгуулах болон бүтэц, үйл ажиллагаа нь ямар байх, төрийн институтын хоорондын харилцаа, зэрэглэл, цаашлаад эрх, үүрэг, хариуцлагыг нь тодорхойлох, эрх мэдлийн хуваарилалтыг зааж өгөх, мөн төрөөс бие хүмүүстэй харилцах үндсэн зарчим зэргийг тогтоон хуульчилдаг. Үндсэн хуулийг үл зөвшөөрсөн, үгүйсгэсэн, эсрэг үйлдэл хийсэн аливаа явдлыг хориглох ба ийм зүйлд олныг уриалсан, өдөөн хатгасан улс төрийн нам, олон нийтийн байгууллага, бүлэглэлийг хуулиар хориглодог. Энэхүү нийгмийн гэрээг хамгаалсан үндсэн механизм болдог маш чухал эрх зүйн баримт бичиг юм. Ингээд гаднын зарим орнуудын Үндсэн хуулийн заалтуудын талаар сонирхуулъя.

Хамгийн эртний ардчилсан уламжлалтай Их Британийн төрийг эдүгээгийн хүчирхэг төр гэж үздэг. Тэд тусгайлсан бичигдмэл Үндсэн хуульгүй ч Төрийн хууль, Ерөнхий хууль, Жишиг хууль гэсэн бүлэг тулгуур хуулийг нийлүүлснийгээ Үндсэн хуулийн хэмжээний суурь хууль гэж үздэг. Төрөөс гаргах шийдвэрийг нарийн зааглаж өгсөн учир зөвхөн харгалзах институт өөрт ноогдсон шийдвэрээ гаргах ба түүнд нь хөндлөнгөөс оролцох боломж маш хязгаарлагдмал.

Хүн төрөлхтний хамгийн анхны Үндсэн хуулийг баталсан үндэстнийг

Харин АНУ-ын Үндсэн хууль өөр нэг дээд амжилтыг эзэмшдэг. Энэ бол хамгийн богино буюу цөөн үгтэй хууль аж. Ердөө 4.4 мянган үг. Тэдний хувьд 1788 онд болсон Тусгаар тогтнолын төлөөх дайны дараа Үндсэн хуулиа баталсан ба 1791 онд 10 нэмэлт, өөрчлөлтийг оруулсан. Эл өөрчлөлтийг түүхэнд "Биллийн эрх" гэж нэрлэдэг. Хожим нь АНУ-ын Үндсэн хуульд нэлээдгүй өөрчлөлт орсноос хамгийн удаан хугацаанд хэлэлцэгдэж орсон өөрчлөлтийг тус Үндсэн хууль эзэмшдэг. Энэ нь 1789 онд Конгрессын гишүүдийн цалин хөлсийг нь нэмэгдүүлж, тодорхой эрхүүдийг хязгаарлах нэмэлт,

"Япон Улс мөнхийн энх тайвныг эрхэмлэх болно" хэмээн тусгажээ. Мөн "Японы Засгийн газар нь үүнээс хойш олон улсын маргаантай асуудлыг шийдвэрлэх үүднээс цэргийн хүчийг хэзээ ч ашиглахгүй" гэж заажээ. Одоогоор тус улсын Зэвсэгт хүчин нь зөвхөн өөрийгөө хамгаалах зорилгоор үйл ажиллагаагаа явуулдаг.

Японтой ижил төстэй Үндсэн хуультай орон бол Мальт юм. Тэд Үндсэн хуульдаа "Мальт Улс нь энх тайвныг идэвхтэй эрэлхийлж буй төвийг сахисан улс" гэж тунхагласан тул аливаа нэгэн цэргийн эвсэлд нэгдэхгүй байх бодлогыг хатуу баримталдаг.

1789 онд Конгрессын гишүүдийн цалин хөлсийг нь нэмэгдүүлж, тодорхой эрхүүдийг хязгаарлах нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэж эхэлсэн бөгөөд 203 жилийн дараа буюу 1992 онд л баталжээ.

өөрчлөлтийг хэлэлцэж эхэлсэн бөгөөд 203 жилийн дараа буюу 1992 онд л баталжээ.

Үндсэн хуулийнхаа агуулга, үгийн тоогоор Энэтхэг өрсөлдөгчгүй тэргүүлдэг. Энэтхэгийн Үндсэн хууль нь 395 зүйл, 12 хавсралт, 500 гаруй заалттай юм. Нэмж хэлэхэд тус Үндсэн хуулийг маш хэцүү үг хэллэгээр бичсэн байдаг тул хуульч л биш бол энгийн иргэд уншаад ойлгодоггүй аж.

Эквадорын Үндсэн хуульд нийгмийн болон хүмүүсийн харилцааг

Австралийн Үндсэн хууль нь 1900 онд батлагдсан "хөгшин" хуульд тооцогдохын зэрэгцээ нэмэлт, өөрчлөлт маш бага орсон байдаг. 120 жилийн хугацаанд зургаан удаа нэмэлт, өөрчлөлт хийсэн ба хамгийн сүүлд 1967 онд нутгийн уугуул иргэдийг хүн амын нэгдсэн тооллогод хамруулахыг хориглосон заалтыг хассан байна.

Египетийн Үндсэн хуульд хэвлэл, мэдээлэлд зориулсан бүхэл бүтэн бүлэг байдаг. Энэхүү бүлгээр хэвлэл, мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулахын зэрэгцээ энэ төрлийн үйл ажиллагааг хориглох нийгмийн харилцааг хязгаарладаг аж. Мөн "хэвлэл, мэдээлэл бол ард түмний бие даасан дөрвө дэх хүч" хэмээн тунхагласан байдаг.

Коста-Рика Улсын Үндсэн хуульд төрийн тэргүүнээ сонгох сонирхолтой заалтууд бий. Тухайлбал, Ерөнхийлөгчид өрсөлдөж буй хүмүүс сонгуулийн үр дүнгээр тэнцүү санал авсан тохиолдолд аль ахмад настайг нь ялагч гэж тооцдог.

Ямайкийн Үндсэн хуульд 1962 оны 8 дугаар сарын 6-ны өдөр буюу Тусгаар тогтнолоо зарласнаас хойш тус улсын нутаг дэвсгэр, түүний харьяа эзэмшил /усан онгоц, агаарын хөлөг, гадаадад суух Элчин сайдын яамны газар/-д төрсөн бүх хүүхдийг иргэнээ болохыг зөвшөөрдөг. Цаашлаад эцэг, эх нь тус улсын иргэний харьяатаас гарсан ч хүүхдүүд нь хүсвэл иргэн нь болох эрхтэй. Гэхдээ улс төрийн болон бусад шалтгаанаас үүдэлтэй дайсагласан хандлагатай улсад төрснөөс бусад хүүхдүүдэд нээлттэй байдаг аж.

Лалын улсуудын Үндсэн хуульд шашны үзэл гүнзгий суусан байдаг. Жишээлбэл, Ливид Үндсэн хууль байдаггүй бөгөөд Коран судар нь эцэг хуулийн үүргийг гүйцэтгэдэг. Мөн Саудын Арабын Нэгдсэн Вант Улсын төрийн албан хаагчид Үндсэн хуульдаа бус Коран судартаа тангараг өргөдөг.



Нобелийн шагналын сонирхолтой баримтууд

Динамит буюу тэсрэх бөмбөгийг зохион бүтээсэн Альфред Нобель өөрийн нийт хөрөнгөнийхөө 90 орчим хувиар сан байгуулж, түүнээс хүн төрөлхтний сайн сайхны төлөө зохион бүтээдэг, туурвидаг, үйлчилдэг хүмүүсийг шагнаж, урамшуулж байхыг гэрээсэлсэн байдаг. Өнөөдөр Нобелийн шагналаар физик, хими, физиологи, анагаах ухаан, уран зохиол, эдийн засгийн шинжлэх ухааны салбар дахь томоохон нээлтүүдийг хийсэн эрдэмтдийг, дэлхийн энх тайвны төлөөх үйлсэд амжилт үзүүлсэн хүмүүсийг алдаршуулан шагнадаг. 1901-2020 оны хооронд ойролцоогоор 600 гаруй хүн Нобелийн шагналыг хүртжээ.

АМЕРИКЧУУД ХАМГИЙН ОЛОН АВСАН

Америкийн эрдэмтэд шинжлэх ухааны салбаруудад олгодог Нобелийн шагналыг хамгийн олон удаа хүртсэн байна. 120 жилийн хугацаанд Нобелийн шагнал авсан нийт хүмүүсийн 43 хувь нь америкчууд юм. Энэхүү үзүүлэлтээр Герман болон Англи удаалдаг.

ШАГНАЛ ХҮРТЭГСДИЙН ТӨРСӨН УЛИРАЛ

Хачирхалтай ч гэсэн Нобелийн шагнал авсан хүмүүсийн ихэнх нь 2 дугаар сарын 28-ны өдрөөс 5 дугаар сарын 21-ний өдрийн хооронд төрсөн байдаг аж.

ДУНДАЖ НАС

Нобелийн шагнал хүртсэн хүмүүсийн дундаж нас 60. Харин хамгийн залуу шагналтан нь Пакистаны хүний эрхийг хамгаалагч Малала Юсуфзаи 2014 онд 17 настайдаа авсан бол хамгийн өндөр настай нь 2019 онд АНУ-ын эрдэмтэн Жон Гудинаф 97 насандаа химийн салбараас Нобелийн шагналыг хүртжээ.

НЭХЭН ШАГНАГДСАН ТОХИОЛДОЛ

1931 онд утга зохиолын салбараас хүртсэн Эрик Карлфельдт, 1961 онд энх тайвны шагналыг хүртсэн Даг Хаммершельд нарт нас барсных нь дараа буюу нэхэн олгосон байна. Энэхүү хоёр тохиолдол нь тухайн цаг үедээ нэлээдгүй шүүмжлэлийг дагуулж байсан тул 1974 онд Нобелийн сангаас шинэ журмыг гарган "нэхэн олгохгүй" байхаар болжээ. Гэвч 2011 онд Нобелийн анагаах ухааны шагналыг Ральф Штайнманд олгохоор болсон ч шийдвэр нь олон нийтэд ил болохоос хэдхэн цагийн өмнө нас баржээ.

ШАГНАЛААС ХАСАГДСАН ШИНЖЛЭХ УХААН

Нобелийн гэрээслэлд математикийн шинжлэх ухааны талаарх нэг ч үг байгаагүй. Тиймээс уг шагналыг математикийн шинжлэх ухааны салбарынханд олгодоггүй. Яагаад оруулаагүй талаар олон таамаг байдаг ч, хамгийн ойрхон байх магадлалтай нь тухайн үед Шведэд "Acta Mathematica" хэмээх нэртэй математикч нарт олгодог шагнал байсантай холбоотой.

ЗӨВХӨН САНГААС ТОДРУУЛДАГҮЙ

Нобелийн шагнал хүртэгсдийг зөвхөн Нобелийн сан тодруулдаггүй. Тухайлбал, физик, хими, эдийн засаг, утга зохиолын салбарыг Шведийн Шинжлэх ухааны академи, биологи-анагаах ухааны салбарыг Каролинскагийн институт, энх тайвны шагналыг Норвегийн парламентаас тус тус шалгаруулдаг. Харин эдийн засгийн салбараас бусад салбарын шагналтнуудын мөнгөн урамшууллыг Альфред Нобелийн сангаас олгодог юм. Эдийн засгийн салбарын шагналтны мөнгөн урамшууллыг Шведийн Төв банкнаас санхүүжүүлдэг бөгөөд нэрийн хувьд "Эдийн засгийн салбар дахь Альфред Нобелийн дурсгалын шагнал" гэж нэрлэдэг.



америкчууд гэж ихэнх хүмүүс боддог. Учир нь бидний үзэж, сонсож байгаа зүйлс дээр АНУ нь эртний Грекийн дараа орох ардчилсан улсыг байгуулсан тухай буруу ойлголттой байдаг. Тэгвэл хамгийн анхны Үндсэн хууль бол Сан-Мариногийнх юм. Энэхүү хуулийг 1600 онд латин үсгээр бичсэн бөгөөд, 1974 онд Хүний эрхийн тунхаглалыг нэмэлтээр тусгасан. Уг хууль нь батлагдсанаасаа хойш хамгийн бага өөрчлөлт орсон Үндсэн хуулийн нэг юм.

зохицуулах заалтаас гадна байгалийн эрхийг тодорхойлсон зүйл, заалт багтдаг. Тиймээс Эквадорын хуулийг хамгийн "ногоон хууль" гэж нэрлэдэг. Ийм өөрчлөлт оруулах болсон гол шалтгаан нь байгаль хамгаалагчдын шүүхэд өгсөн гомдлын тоо дэндүү их байсан тул Үндсэн хуульдаа тусган асуудлыг шийджээ.

Үндсэн хуульдаа хамгийн энх тайвныг эрхэмлэсэн улс бол Япон. Дэлхийн хоёрдугаар дайны дараа 1947 онд баталсан Үндсэн хуульдаа